



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Отгоны САРАНЧУЛУУН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-56, Факс: 32-70-16
E-mail: saranchuluun@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.12.17 № УИХ-03/14440
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 33 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.САРАНЧУЛУУН

Ж.АЛДАРЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

Н.АЛТАНХУЯГ

Н.АЛТАНШАГАЙ

Д.АМАРБАЯСГАЛАН

С.АМАРСАЙХАН

О.АМГАЛАНБААТАР

00000621

Ч.АНАР



А.АРИУНЗАЯА

Т.АУБАКИР

Х.БААСАНЖАРГАЛ

Ц.БААТАРХҮҮ

М.БАДАМСҮРЭН

Э.БАТ-АМГАЛАН

Б.БАТБААТАР

Д.БАТБАЯР

Р.БАТБОЛД

Ж.БАТЖАРГАЛ

Д.БАТЛУТ

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.БАТСУУРЬ

Н.БАТСҮМБЭРЭЛ

Х.БАТТУЛГА

Б.БАТЦЭЦЭГ

П.БАТЧИМЭГ

Э.БАТШУГАР

Б.БАТ-ЭРДЭНЭ



Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРБААТАР

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

Б.БЕЙСЕН

00000621

Х.БОЛОРМАА

Э.БОЛОРМАА

Х.БУЛГАНТУЯА

Д.БУМ-ОЧИР

Ш.БЯМБАСҮРЭН

С.БЯМБАЦОГТ



Ж.ГАЛБАДРАХ

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

Ж.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

П.ГАНЗОРИГ



Д.ГАНМАА

Л.ГАНТӨМӨР

Х.ГАНХУЯГ

М.ГАНХҮЛЭГ

Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Х.ЖАНГАБЫЛ

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

С.ЗАМИРА



00000621

Б.ЗАЯАБАЛ

Ж.ЗОЛЖАРГАЛ

С.ЗУЛПХАР

Ц.ИДЭРБАТ

Ч.ЛОДОЙСАМБУУ

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЛҮНДЭГ

М.МАНДХАЙ

Л.МӨНХБААТАР

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

Т.МӨНХСАЙХАН

Б.МӨНХСОЁЛ

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

З.МЭНДСАЙХАН

Б.НАЙДАЛАА

Н.НАРАНБААТАР

П.НАРАНБАЯР

М.НАРАНТУЯА-НАРА

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

Н.НОМТОЙБАЯР

Э.ОДБАЯР

С.ОДОНТУЯА

У.ОТГОНБАЯР

00000621



Г.ОЧИРБАТ
Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Б.ПУНСАЛМАА
Д.ПҮРЭВДАВАА



Б.ПҮРЭВДОРЖ
Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ
Ц.САНДАГ-ОЧИР
М.САРНАЙ



Л.СОРОНЗОНБОЛД
Р.СЭДДОРЖ
Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН



Х.ТЭМҮҮЖИН
Г.ТЭМҮҮЛЭН
А.УНДРАА



Ч.УНДРАМ
Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР

00000621

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЛАН

Б.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

00000621



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
ОТГОНЫ САРАНЧУЛУУН**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-56, Факс: 32-70-16
E-mail: saranchuluun@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.10.03 № УИХ-03/11448
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов
тогтоолгох тухай

Улсын Их Хурлын гишүүн миний бие Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, хэлэлцүүлэн тус хуулийн 40 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж, бүрдүүлбэрийн хамт хүргүүлж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянан үзэж, Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 129 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.САРАНЧУЛУУН

00000532



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.САРАНЧУЛУУН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.08.27 № ХТ/2308
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255010101

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын санаачлан боловсруулсан Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын санаачлан боловсруулсан Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 15-д “хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал; нийгмийн халамжийн бодлого; хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт” нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар хуульчилсан.

Дээрх асуудлын хүрээнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, тогтолцоог Нийгмийн халамжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт тодорхойлохдоо “нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ” гэж, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ” гэж тус тус заасан.

Иймд хуулийн төсөлд тусгасан нийгмийн ажил, үйлчилгээ, нийгмийн ажилтны эрх зүйн байдал, удирдлага, зохион байгуулалтын талаарх зарим зохицуулалт нь дээрх хууль тогтоомжид заасан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудал, бүрэн эрх, чиг үүрэгтэй давхцаж, хуулийн давхардал, хийдэл, зөрчил үүсгэж болзошгүй байна;

2.Хуулийн төсөлд төрийн бус байгууллагын буюу Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг зохицуулахаар тусгажээ.

Мэргэжлийн холбооны үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус зохицуулдаг бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлж болохоор заасан тул хуулийн төсөлд тусгасан мэргэжлийн холбооны үйл ажиллагааг дээрх хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.

Түүнчлэн, хуулийн төслийн гол зохицуулалт болох Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулах, холбооны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, мөн нийгмийн ажилтнуудыг холбооны гишүүнчлэлтэй болгох, гишүүнчлэлийн хураамж төлөх зэрэг асуудлын талаар хуулийн төслийн тандан судалгаанд тусгаагүй, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн дунд хуулийн төслийг хэлэлцүүлж, санал авсан эсэх нь тодорхойгүй байна.

Иймд хуулийн төсөл, үзэл баримтлал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан хуулийн төслийн үзэл баримтлалыг судалгаа хийсний үндсэн дээр боловсруулах, хуулийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулах гэсэн хуулийн шаардлагад нийцэхгүй байна;

3.Хуулийн төслийн зардлын тооцоололд хуулийн төсөлтэй холбоотой анхны хөрөнгө оруулалт 0.8 тэрбум төгрөг, цаашид жил бүр 96.5-160.0 тэрбум төгрөг шаардагдах бөгөөд ажилтны тоог харгалзвал төсвийн дарамт нэмэгдэхээр дурдсан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 2025 оны түвшинд хадгалах, Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-д төсвийн урсгал зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасантай тус тус нийцэхгүй байна;

4.Хуулийн төсөлд Нийгмийн ажилтны мэргэжлийн холбоог нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох чиг үүрэгтэй байхаар тусгаж, хуулийн төслийг дагалдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нийгмийн ажлын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг Нийгмийн ажилтны мэргэжлийн холбоо олгох заалтыг нэмэх тухай хуулийн төсөл боловсруулжээ.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзах бөгөөд мөн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 болон 5 дахь хэсэгт заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ерөнхий сайдын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн санал, дүгнэлт гаргуулах шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй;

5.Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, өргөн мэдүүлэхээр заасан.

Нийгмийн ажил, үйлчилгээг сайжруулах, салбар дундын уялдааг хангах, хүн амын тодорхой бүлэгт нийгмийн ажил, үйлчилгээг хүргэх, суурь хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн ажлын тогтолцоог сайжруулах зорилгоор анхдагч хуулийн төсөл боловсруулахаас илүүтэйгээр хуулийн төсөлд туссан зарим зохицуулалтыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд болон салбарын бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль тогтоомжийн уялдааг хангах, зохицуулалтыг сайжруулах байдлаар шийдвэрлэх боломжтой;

6.Хуулийн төсөл, дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл нь “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан анхдагч хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулахад тавих шаардлага болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй, үг, үсэг, утга найруулгын илэрхий алдаатай байгааг дурдах нь зүйтэй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

О.САРАНЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

Х.БУЛГАНТУЯА

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

А.АРИУНЗАЯА

НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2025 оны 06 дугаар сарын 27

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгыг бүрдүүлэхээр тунхаглаж, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцахаар заасан ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хүн амын тодорхой бүлэгт чиглэсэн нийгмийн ажил, үйлчилгээ хүртээмжгүй, харилцан адилгүй байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22 дугаар зүйлд “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.”, НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд “Энэхүү Пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө.” гэж тус тус заасан.

Хүн амын тодорхой хэсэг, бүлэг нь, тухайлбал бага орлоготой өрх, эрсдэлт нөхцөлд буй хүүхэд өсвөр үеийнхэн, шилжин суурьшигчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд, архаг хүнд өвчтэй хүмүүс, байгалийн гамшигт өртсөн олон нийт болон тэдний гэр бүл нь амьдралынхаа тодорхой үе шатуудад нийгмийн хамгааллын үйлчилгээг үр дүнтэй авах хэрэгцээ, шаардлагын дагуу 1900-аад оноос барууны орнуудад үүссэн нийгмийн ажлын салбар, нийгмийн ажилтны мэргэжил нь 1950-иад оноос эрчимтэй хөгжиж, гадаадын ихэнх орнууд Нийгмийн ажил үйлчилгээний тусгайлсан хууль гарган зохицуулж иржээ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийгмийн ажлын үйлчилгээний зохицуулалт, чиглэл, хамрах хүрээ, үйл ажиллагааг харилцан адилгүй тодорхойлж, зөвхөн тухайн салбарын онцлогийг харгалзан тусгасан нь хэт явцуу бөгөөд салбар дундын хамтын уялдаагүй, мөн мэргэжлийн үйл ажиллагаа эрс ялгаатай байдлаар тодорхойлсон байна.

Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дах хүний эрхийн төлөв байдлын 19, 20, 21, 22, 23 дахь илтгэлүүд Монгол Улсад нийгмийн ажил, үйлчилгээ нь олон улсын жишгээр мэргэжлийн түвшинд хүртээмжтэй бус байгаагаас нэн тэргүүнд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм, эдийн засгийн эрх зөрчигдөж, улмаар

хүчирхийлэлд өртөх, амьдралын чанар буурах зэрэг дагалдах эрсдэл үүссээр байгаа талаар тусгагдсан байна.

Монгол Улсад нийгмийн ажлыг хүн амын, нийгмийн онцлог хэрэгцээнд тулгуурлан, бие даасан онол-арга зүйтэй шинжлэх ухаан, практик чиг баримжаатай ажил, мэргэжил болохынх нь хувьд улам хөгжүүлж, бусад салбарын нэгэн адил системтэй мэдлэг, хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэн, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйл, зарчимтай байх шалгууруудыг нь хүлээн зөвшөөрч нийгмийн хамгааллынхаа үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэх шаардлагатай. Ингэснээр нийгмийн сэтгэл зүй, эрүүл мэндийн салбарынхаа үйлчилгээ, үйл ажиллагааг хүн амынхаа бодит хэрэгцээнд тулгуурлан хүргэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангуулах, халамж хамгаалал шаардлагатай бүлэгт хүрч очих, хүний суурь хэрэгцээг хангах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзсэн болно.

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11 дэх хэсэгт "... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын Зорилго 2-т "Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ." гэж, мөн зорилгын 3 дах хэсэгт "Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ." гэж; мөн баримт бичгийн "2.2.10-д Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.", "2.3.1-д "Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ", "2.3.3-д Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.", "2.3.6-д Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ." ... гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хоёр. Хүний хөгжлийн бодлогын 2.1.1-д Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого хэсэгт 2.1.3.8.Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална гэж заасан.

Олон улсын Нийгмийн ажлын холбоо Нийгмийн ажлын боловсрол ба сургалтын дэлхийн стандарт, MNS 5323-94 Нийгмийн ажлын дээд боловсролын Монгол Улсын

стандарт, MNS 5852 Монгол улсын стандарт, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага стандарт болон Монголын Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байгаа хэдий ч салбар бүрд ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдлыг хангах, ажил үйлчилгээг нэгдсэн тогтолцоо, удирдлагаар хангах, хамтын ажиллагаа, оролцоог сайжруулахад нийтлэг мөрдөх эрх зүйн баримт бичиг байхгүй нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон.

Практик шаардлага

Дэлхий дахинд нийгмийн ажилтнууд нь эмч, багш, хуульч зэрэг бусад мэргэжилтнүүдийн нэгэн адил мэргэжлийн ур чадвараа гаргаж, ёс зүйн хэм хэмжээг баримталж, мэргэжлийн дадлага хийж, тусгай шалгалт өгч, зөвшөөрөл авч ажилладаг практик тогтолцоо хөгжсөн бөгөөд Их Британи, АНУ-д нийгмийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрч, тэдний цалинг улсын дундаж цалингийн түвшнээс дээгүүр тогтоосон байдаг. Харин Монгол Улсад нийгмийн ажилтнууд төрийн захиргааны алба хаагч, ажилтнаас бага, улсын дундаж цалингийн тал хувьтай тэнцэх хэмжээний цалин авч байна. Цалингийн хэмжээ, урамшуулал, нэмэгдэл нь ажлын ачаалал болон гүйцэтгэлийн үр дүнтэй харилцан хамааралгүй бөгөөд нийгмийн ажилтан ажиллаж буй салбар бүрд ялгаатай байгаа нь хүний нөөцийн оновчтой хувилбар боловсруулах, нэгдсэн стратеги төлөвлөгөөгөөр ажиллуулахад хүндрэлтэй байна.

Монгол Улсын нийт 1,2 сая хүүхэд, тэдний 30 хувь нь бага орлоготой өрхийнх, 150000 гаруй ахмад настнууд хүнд нөхцөлд байгаа, 120000 орчим дэмжлэг хэрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Түүнчлэн Монгол Улсын нийт хүн амын 10.9% нь ахмад настан бөгөөд хоёр ахмад настны нэг нь сэтгэлзүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай; 39% нь 0-18 насны хүүхэд бөгөөд тодорхой хувь нь хүнд нөхцөлд амьдардаг; 3% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 30-40% нь ядуурлын түвшинд амьдарч байгаа нь нийгмийн ажлын хэрэгцээ дутагдаж байгааг цаашид шийдвэрлэх нь зүйтэй.

Монгол улсад нийгмийн үйлчилгээний 5 салбарт нийт 2634 нийгмийн ажилтан ажиллаж байгаа боловч тус нийгмийн ажилтнуудын 30 хувийг нийгмийн ажлын мэргэжлийн зэрэгтэй, 70 хувийг бусад мэргэжлийн зэрэгтэй ажилтнууд бүрдүүлж байна. Ажлын байрны болон нийгмийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа хэдий ч дотоодын их, дээд сургуулиудыг жил бүр дунджаар 290 нийгмийн ажилтан мэргэжлээр төгсөж байна.

2020 оны мэргэжлээрээ ажилладаггүй төгсөгчдийн судалгаанд нийгмийн ажлын мэргэжлээр үргэлжлүүлэн ажиллахгүй байгаа шалтгааныг ажлын ачаалал орчин нөхцөл маш хүнд боловч ажлын цалин урамшуулал бага, ажил үүрэг тодорхойгүй, удирдлага мэргэжлийн онцлогийг ойлгодоггүй, мэргэжлийн ахиц дэвшил тодорхойгүй гэж дүгнэсэн байна.

Монгол Улсад нийт 758 хүүхэд хамгааллын хамтарсан баг 6318 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хамтарсан багийн гишүүдийн 699 нь нийгмийн ажилтан бөгөөд тус нийгмийн ажилтнуудын 419 нь нийгмийн ажлын мэргэжлийн бус ажилтнууд ажиллаж байна. Түүнчлэн нийслэлийн хэмжээнд 204 хүүхэд хамгааллын хамтарсан баг 1176 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Түүнээс 396 гишүүн нь нийгмийн ажлын мэргэжилтэн байх ёстой боловч бодит байдал дээр 171 нийгмийн ажилтан ажиллаж байна. Дээрх судалгаанаас үзвэл, ажиллах хүчний нөөц боломж сул, ажиллаж байгаа

одоогийн ажиллах хүч нь байх ёстой орон тооноос 20-30 орчим хувиар бага боловч ажилтнуудын 60 орчим хувь нь мэргэжлийн бус ажилтнууд байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль тусгагдсан хамтарсан багийн нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд заасан олон чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд 20 гаруй төрлийн судалгаа хөтөлж, хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчид сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, хохирогчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээнд хамруулах зэргээр тус багийн нийт үйл ажиллагааны 80-90 хувийг дангаар гүйцэтгэж байгаа боловч цалин урамшууллын хувьд Үндэсний статистикийн хорооноос тодорхойлсон дундаж цалингаас 29-өөс 59 хүртэл хувиар бага байна.

Бага насны хүүхэд болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай гэр бүл хувь хүн, архаг хүнд өвчтэй хүнтэй ажиллах нийгмийн ажилтны нарийвчилсан үйлчилгээний стандарт, аргазүй тодорхойгүй байна. Тухайлбал хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх арга хэмжээг сургуулийн нийгмийн ажилтан, багш нар хувийн туршлага арга зүйд үндэслэн шийдвэрлэж байгаа нь зарим тохиолдолд хүртээмжгүй оновчгүй эсвэл тохиромжгүй байна.

Монгол улсад мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ авсан иргэд, гэр бүл, олон нийтийн талаарх ахиц дэвшил, өөрчлөлт болон бие даасан байдлын өсөлтийг харуулсан эргэх холбоо бүхий мэдээллийн нэгдсэн сан байхгүй. Үйлчилгээ үр дүнтэй залгамж холбоотой хүртээмжтэй байхын тулд нийгмийн ажлын бусад мэргэжилтнүүдтэй хамтрах бодит мэдээллийн санг байгуулах шаардлагатай. Мөн үйлчилгээ үр дүнтэй эсэхийг бүх шатанд үнэлэх, дахин төлөвлөх үйл ажиллагаа хийгдэхгүй байгаа нь нэгдсэн мэдээллийн сан байгуулагдаагүйгээс шалтгаалж байна.

Нийгмийн ажлын мэргэжлийн үнэт зүйл, ёс зүйн, стандартын талаарх нэгдмэл ойлголт их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр болон бусад шатны урт болон богино хугацааны хөтөлбөрүүдэд харилцан адилгүй туссан байх тул нэгдсэн мэргэжлийн үнэт зүйлийг тодорхойлох хөтөлбөрийг боловсруулах тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн нийгмийн завсрын бүлгүүд болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд, эрсдэлт нөхцөлд бага насны хүүхдүүдийг дам эрсдэлээс урьдчилан сэргийлэх нийгмийн тогтолцоо бүрдээгүй байна.

Иймд дээрх хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийг боловсруулах замаар нийгмийн ажлын салбар болон салбарын мэргэжилтнүүдэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын дагуу нийгмийн ажлын тухай эрх зүйн зохицуулалтыг анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна. Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийн зорилго нь нийгмийн ажил, үйлчилгээний дэд бүтэц болох нийгмийн ажилтны мэргэжлийн хүрээ, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байгаа бөгөөд салбар дундын уялдаа холбоонд суурилсан нийгмийн ажлын үйлчилгээг дараах үндсэн зарчимд нийцүүлэн боловсруулна. Үүнд:

1.Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Нийгмийн ажлын мэргэжлийн тусламж үйлчилгээг хуульд заасан тодорхой эрсдэл, нөхцөл бүрдсэний дараа үзүүлэхээр тусгасныг өөрчилж, урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа болон иргэний хэрэгцээ шаардлагад суурилж хүргэх зохицуулалт бий болгоно. Тухайлбал, сургууль, хороо, эмнэлэгт ажиллаж буй нийгмийн ажилтан нь иргэдийнхнээ хэрэгцээ шаардлагыг судалж нотолгоонд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна.

2.Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын урьдчилан сэргийлэх, үр дүнтэй үйлчилгээг хүргэх тогтолцоо бүрдүүлнэ. Бага орлоготой айл өрх, эрсдэлт нөхцөлд буй хүүхэд, туслалцаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй болон архаг хүнд өвчтэй хүмүүс, гэнэтийн осол гэмтлийн дараах, мэс заслын дараа үүсэх дагалдах хүндрэлээс урьдчилсан сэргийлсэн, сургасан, хамгаалсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна. (жишээлбэл, архаг өвчинтэй хүн сэтгэл гутралд өртөх, хүчирхийлэлд өртсөн хүн осол гэмтлийн эрсдэлтэй байх гэх мэт).

3.Нийгмийн ажлын үйлчилгээний нэгдсэн тодорхойлолт, түүний төрөл хэлбэр, үе шат, эргэх холбоо, тайлагналт, мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах арга хэлбэр, нийтлэг эрх үүргийг тодорхой болгож, мэргэжлийн үнэ цэнийг өсгөнө.

4.Олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд эрүүл мэнд, боловсрол, хууль сахиулах, нийгмийн халамж салбарт ажиллаж буй нийгмийн ажилтны багт гүйцэтгэх үүрэг, оролцооны хүрээ, хязгаарыг тодорхой болгож, бүтээмж, үр дүнг нь бодитоор үнэлэх, хэмжих тогтолцоог бий болгоно.

5.Өөрийн амьдралынхаа шийдвэр гаргах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өөрийгөө удирдах чадварыг дэмжихийн тулд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан бүх иргэдийг бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох ур чадвар, мэдлэгээ хөгжүүлэхэд сургаж, ахиц дэвшлийг үнэлдэг хэм хэмжээг бий болгоно.

6.Өөрийгөө төлөөлөх чадваргүй, эсхүл насанд хүрээгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхэм чанар, нэр төр, алдар хүндийг эрхэмлэсэн нийгмийн үйлчилгээг бий болгохын тулд хувь хүний мэдээллийг хариуцлагатайгаар хадгалж, зөвхөн шаардлагатай буюу аюулаас сэргийлэх болон судалгаа, үнэлгээний хүрээнд мэргэжлийн зорилгоор ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.

7.Нийгмийн ажилтны мэргэжлийн хариуцлагын тогтолцоог бий болгоно. Нийгмийн ажилтан нь аль ч салбарт ажиллаж байгаагаас үл хамааран нэгдсэн арга зүй, нэг стандартаар хэрэгжүүлэх, тайлагнах, ёс зүй мэргэжлийн хариуцлагын тогтолцоотой болно. Ингэхийн тулд мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэж, онцгой нөхцөлд ажиллах эрх олгох тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой мэргэжлийн үргэлжилсэн сургалтын тогтолцоотой болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Нийгэм, эдийн засгийн үр дагавар:

1.Ажил эрхлэлт ба татварын орлого нэмэгдэх

Нийгмийн халамжийн чанартай үйлчилгээг үзүүлснээр хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжгүй иргэдийн (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, ганц бие эцэг эхчүүд гэх мэт) чадавх нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлт сайжирна. Тухайлбал, ажлын байр идэвхтэй хайж буй иргэдийн тоо нэмэгдэнэ, ажиллах хүчний хомсдол буурч, эдийн засгийн идэвх нэмэгдэнэ. Халамжид суурилсан эдийн засгийн ачаалал багасаж, урт хугацаандаа эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ.

2. Ядуурлыг бууруулах

Нийгмийн хамгааллын тогтолцоонд чадваржуулах нийгмийн ажлын үйлчилгээг нэвтрүүлснээр ядуу болон эмзэг бүлгийн иргэдэд хүрч буй дэмжлэг туслалцаа үг өгөөжтэй болж санхүүгийн дарамтаас гарсан иргэд хэрэглээгээ нэмэгдүүлж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

3. Эрүүл мэндийн боловсролын сайжрах.

Нийгмийн ажлын хуулийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ хүртээмжтэй болсноор иргэдийн бүтээмж нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл иргэдийн эрүүл мэндийн хариуцлага нь нэмэгдэж, улмаар дам эрсдэл буурч, эрүүл мэндийн зардал буурч, эрүүл мэндийн системд ирэх ачааллыг багасгана.

4. Бизнесийн орчин сайжрах

Нийгмийн хамгааллын тогтолцоо сайжирснаар ажилчдын амьдралын чанар дээшилж, ажлын бүтээмж өснө. Мөн бизнес эрхлэгчдийн хувьд ажиллах хүчний тогтвортой байдал нэмэгдэж, ажилчдын эрүүл мэндийн болон нийгмийн асуудлууд багасах учир урт хугацаанд ашигтай байх болно.

5. Төрийн үйлчилгээний шударга байдал, тэгш эрхийн үнэлэмжийг нэмэгдүүлэх.

Иргэд нийгмийн хамгааллын үйлчилгээг тэгш хүртэх боломжтой болно. Хүйс, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал үүсэл, хаана амьдарч байгаагаас үл хамааран хүн бүрд эрх тэгш боломж бүрдэнэ.

6. Гэр бүлийн, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар сайжрах

Хүүхэд хамгааллын үйлчилгээ сайжирч, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчил буурна. Гэр бүлийн тогтвортой байдал нэмэгдэж, гэр бүл цуцлалт буурна.

7. Нийгмийн идэвх, оролцоо нэмэгдэх

Иргэд сайн дурын ажил, нийгмийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцоно. Итгэлцэл нэмэгдэж, иргэний нийгэм бэхжих боломжтой. Сонгууль, орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

Хууль зүйн үр дагавар

1. Хууль эрх зүйн тогтвортой байдал нэмэгдэх

Нийгмийн ажлын эрх зүйн зохицуулалт тодорхой болж, иргэдийн эрхийг хамгаалах тогтолцоо сайжирна. Олон улсын хүний эрхийн стандарт, нийгмийн хамгааллын зарчимд нийцсэн хууль тогтоомж бий болно. Хууль хэрэгжүүлэх байгууллагуудын (цагдаа, шүүх, халамжийн газар) уялдаа сайжирч, маргааныг үр дүнтэй шийдвэрлэх боломжтой болно.

2. Иргэний эрхийг хамгаалах баталгаажилт нэмэгдэх

Иргэдийн нийгмийн хамгааллын эрх зүйн орчин тодорхой болж, хамгаалагдах боломж нэмэгдэнэ. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, өндөр настны эрхийг зөрчсөн тохиолдолд эрх зүйн хамгаалалт сайжирна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүйчүүд, ядуу иргэд, орон гэргүй хүмүүсийн хууль ёсны эрхийг хамгаалах механизмууд бий болно.

3. Нийгмийн ажлын мэргэжлийн стандарт, хариуцлага нэмэгдэх

Нийгмийн ажилтнуудын мэргэжлийн стандарт, үүрэг, эрхийг тодорхой болгож, ажлын хариуцлагыг сайжруулна. Хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн ажилтнууд мэргэжлийн үйл ажиллагаагаа стандартын дагуу явуулж, үйлчилгээний чанар дээшилнэ. Хууль бус, мэргэжлийн бус үйл ажиллагааг хязгаарлах боломж бүрдэнэ.

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчин сайжрах

Ядуурал, ажилгүйдэлтэй холбоотой гэмт хэргийг бууруулах хууль эрх зүйн боломж бүрдэнэ. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хууль эрх зүйн бодлого хэрэгжинэ. Нийгмийн хамгаалал сайжирснаар хууль бус үйл ажиллагаа (хүн худалдаалах, хүүхдийн хөдөлмөр мөлжлөг гэх мэт) багасах боломжтой.

5. Төрийн байгууллагуудын үүрэг, уялдаа сайжрах

Төрийн болон төрийн бус байгууллагууд нийгмийн хамгааллын чиглэлээр хамтран ажиллах эрх зүйн орчин бий болно. Орон нутгийн захиргаа, цагдаа, шүүх, нийгмийн халамжийн байгууллагуудын ажлын уялдаа сайжирна. Төрийн нийгмийн үйлчилгээний хүртээмж, санхүүжилт нэмэгдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Ахмад настны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---oOo---

НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилго 2-т “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.” гэж, мөн зорилгын 3 дах хэсэгт “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж; мөн баримт бичгийн “2.2.10-д Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.”, “2.3.1-д “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ”, “2.3.3-д Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.”, “2.3.6-д Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” ... гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хоёр. Хүний хөгжлийн бодлогын 2.1.1-д Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого хэсэгт 2.1.3.8.Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална гэж заасан.

Олон улсын Нийгмийн ажлын холбоо Нийгмийн ажлын боловсрол ба сургалтын дэлхийн стандарт, MNS 5323-94 Нийгмийн ажлын дээд боловсролын Монгол Улсын стандарт, MNS 5852 Монгол улсын стандарт, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага стандарт болон Монголын Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байгаа хэдий ч салбар бүрт ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдлыг хангах, ажил үйлчилгээг нэгдсэн тогтолцоо, удирдлагаар хангах, хамтын ажиллагаа, оролцоог сайжруулахад нийтлэг мөрдөх эрх зүйн орчин бүрдээгүй нь энэхүү хуулийн төслийг боловсруулах үндэслэл болсон.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжинд нийгмийн ажлын чиг үйлчилгээний зохицуулалт, чиглэл, хамрах хүрээ, үйл ажиллагааг харилцан адилгүй тодорхойлж, зөвхөн тухайн салбарын онцлогийг

харгалзан тусгасан нь хэт явцуу бөгөөд салбар дундын хамтын уялдаагүй, мөн мэргэжлийн үйл ажиллагаа эрс ялгаатай байдлаар тодорхойлсон байна.

Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дах хүний эрхийн төлөв байдлын 19, 20, 21, 22, 23 дахь илтгэлүүд Монгол Улсад нийгмийн ажил, үйлчилгээ нь олон улсын жишгээр мэргэжлийн түвшинд хүртээмжтэй бус байгаагаас нэр тэргүүнд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм, эдийн засгийн эрх зөрчигдөж, улмаар хүчирхийлэлд өртөх, амьдарлын чанар буурах зэрэг дагалдах эрсдэл үүссээр байгааг дүгнэсэн байна.

Монгол Улсад нийгмийн ажлыг хүн амын, нийгмийн онцлог хэрэгцээнд тулгуурлан, бие даасан онол-арга зүйтэй шинжлэх ухаан, практик чиг баримжаатай ажил, мэргэжил болохынх нь хувьд улам хөгжүүлж, бусад салбарын нэгэн адил системтэй мэдлэг, хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэн, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйл, зарчимтай байх шалгууруудыг нь хүлээн зөвшөөрч нийгмийн хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэх шаардлагатай.

Нийгмийн сэтгэл зүй, эрүүл мэндийн салбарынхаа үйлчилгээ, үйл ажиллагааг хүн амынхаа бодит хэрэгцээнд тулгуурлан хүргэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангуулах, халамж хамгаалал шаардлагатай бүлэгт хүрч очих, хүний суурь хэрэгцээг хангах, амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзсэн болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын дагуу нийгмийн ажлын тухай эрх зүйн зохицуулалтыг анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсрууллаа.

Хуулийн төсөл 7 бүлэг 49 зүйлтэй бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

1.Хуулийн төсөлд нийгмийн ажлын мэргэжлийн тусламж үйлчилгээг хуульд заасан тодорхой эрсдэл, нөхцөл бүрдсэний дараа үзүүлэхээр тусгасан бусад хууль тогтоомжийн зохицуулалтыг өөрчилж, урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа болон иргэний хэрэгцээ шаардлагад суурилж хүргэх зохицуулалт бий болгоно.

2.Мөн хуулийн төсөлд зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн хамгаалалын урьдчилан сэргийлэх, үр дүнтэй үйлчилгээг хүргэх тогтолцоо бүрдүүлнэ. Бага орлоготой айл өрх, эрдсэлт нөхцөлд буй хүүхэд, туслалцаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй болон архаг хүнд өвчтэй хүмүүс, гэнэтийн осол гэмтлийн дараах, мэс заслын дараа үүсэх дагалдах хүндэрлээс урьдчилсан сэргийлсэн, сургасан, хамгаалсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна.

3.Нийгмийн ажлын үйлчилгээний нэгдсэн тодорхойлолт, түүний төрөл хэлбэр, үе шат, эргэх холбоо, тайлагналт, мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, бусад мэргэжлнтнүүдтэй хамтран ажиллах арга хэлбэр, нийтлэг эрх үүргийг тодорхой болгоно.

4.Олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж эрүүл мэнд, боловсрол, хууль сахиулах, нийгмийн халамж салбард ажиллаж буй нийгмийн ажилтны багт гүйцэтгэх үүрэг, оролцооны хүрээ, хязгаарыг тодорхой болгож, бүтээмж, үр дүнг нь бодитоор үнэлэх, хэмжих тогтолцоог бий болгохоор тусгана.

5.Өөрийн амьдралынхаа шийдвэр гаргах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өөрийгөө удирдах чадварыг дэмжихийн тулд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан бүх иргэдийг бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцох ур чадвар, мэдлэгээ хөгжүүлэхэд сургаж, ахиц дэвшлийг үнэлдэг хэм хэмжээг бий болгоно.

6.Өөрийгөө төлөөлөх чадваргүй, эсхүл насанд хүрээгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхэм чанар, нэр төр, алдар хүндийг эрхэмлэсэн нийгмийн үйлчилгээг бий болгохын тулд хувь хүний мэдээлэлийг хариуцлагатайгаар хадгалж, зөвхөн шаардлагатай буюу аюулаас сэргийлэх болон судалгаа, үнэлгээний хүрээнд мэргэжлийн зорилгоор ашиглах тогтолцоог бүрдүүлэхээр заана.

7.Хуулийн төсөлд нийгмийн ажилтны мэргэжлийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхээр тусгах бөгөөд нийгмийн ажилтан нь аль ч салбарт ажиллаж байгаагаас үл хамааран нэгдсэн арга зүй, нэг стандартаар хэрэгжүүлэх, тайлагнах, ёс зүй мэргэжлийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхээр заана.

Хуулийн төсөл батлагдсаны батлагдсанаар нийгмийн ажлын үйлчилгээний эрх зүйн орчин тодорхой болж хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжгүй иргэдийн (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, ганц бие эцэг эхчүүд гэх мэт) чадавхи нэмэгдэж, хөдөлмөрлөл эрхлэлт сайжирна. Мөн нийгмийн хамгааллын тогтолцоонд чадваржуулах нийгмийн ажлын үйлчилгээг нэвтрүүлсэнээр ядуу болон эмзэг бүлгийн иргэдэд хүрч буй дэмжлэг тусалцаа үг өгөөжтэй болж санхүүгийн дарамтаас гарсан иргэд хэрэглээгээ нэмэгдүүлж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

---oOo---

“НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ” АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлал, Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батласан аргачлалын дагуу боловсруулсан. Тус хуулийн төсөлд олон нийтээс тус хуулийн төсөлд parliament сайтад ирүүлсэн 32 санал, 2024 оны 11 сараас 2025 оны 9 сарын 18-ны өдрийг хүртэл хугацаанд 11 удаагийн, давхардсан тоогоор 820 гаруй нийгмийн ажилтныг хамруулсан хэлэлцүүлгээс гарсан 250 орчим санал, Засгийн газрын санал, дүгнэлтийг тусган нийт 7 бүлэг 49 зүйлтэйгээр боловсруулсан. Уг хуулийн төслийн бүлэг тус бүрээр дараах эрх зүйн харилцааг зохицуулахыг зорьсон болно. Үүнд:

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл хэсэг:

Тус бүлэгт нийгмийн ажлын тухай хуулийн зорилт, нийгмийн ажлын хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, нийгмийн ажлын зарчим зэргийг зохицуулж өгсөн. Хуулийн дээрх бүлэг нь 5 зүйлтэй байхаар төсөл тусгагдсан бөгөөд нийгмийн ажлын хуулийн зорилт нь нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, салбар хоорондын уялдаатай нийгмийн ажлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай, тасралтгүй хүргэх тогтолцоог бүрдүүлэх, хүний бие даан шийдвэр гаргах чадварыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах үндсэн зорилготой байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн ажлын тогтолцоог хуульчлан бэхжүүлж, мэргэжлийн стандартыг тогтоох бөгөөд эмзэг бүлгийн игэдэд цогц чанартай үйлчилгээ хүргэх боломжийг бүрдүүлэх юм.

Нөгөөтэйгүүр, бусад мэргэжлийн холбоодын хувьд өөрсдийн гэсэн бие даасан хуультай болсон байна. Тухайлбал, Хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, Аялал жуулчлалын холбоо гэх мэт. Түүнчлэн, салбар хоорондын уялдаатай нийгмийн ажлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай, тасралтгүй хүргэх тогтолцоог бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой байгаа учраас нийгмийн ажлын тухай хуулийн анхдагч хууль батлагдах нь зайлшгүй шаардлагатай байна.

Мөн хуулийн төслийн уг бүлэгт нийгмийн ажил, нийгмийн ажил үйлчилгээ, нийгмийн ажилтан зэрэг ойлголтыг нэр томъёоны хувьд нэг мөр тодорхойлж өгсөн. Тодруулбал, “Нийгмийн ажил” гэж нийгмийн хөгжил, өөрчлөлт, нийгмийн эв нэгдлийг дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг хангах, тэднийг чадавхжуулахад чиглэсэн мэргэжлийн арга зүй бүхий цогц үйл ажиллагаа” гэж тодорхойлсон бөгөөд уг үйл ажиллагааны төрлийг нэг бүрчлэн дараагийн бүлэгт хуульчлан тусгасан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2023 онд хийсэн судалгаанаас үзвэл Нийгмийн ажилтнуудын 56% /3500 ажилтнаас 1960 хүн/ мэргэжлийн боловсролгүй, 21 аймгийн 330 сумын 60 хувь нь ажлын байрны стандартыг хангаагүй байсан байна. Энэ нь эрх зүйн зохицуулалтын дутагдал, ажлын нөхцөл, санхүүжилтийн хязгаарлалт, нийгмийн буруу хандлага, салбар хоорондын уялдаа байдалтай холбоотой юм.

Тэрчлэн, Нийгмийн ажлын зарчмыг хуульчилж тусгасан бөгөөд нийгмийн ажилтнууд мэргэжлийн үйл ажиллагаандаа нэгдсэн арга зүйг баримталж, салбарын уялдааг хангаж ажиллах боломжийг хуулиар баталгаажуулах юм.

Хүн амын тодорхой хэсэг, бүлэг нь, тухайлбал бага орлоготой өрх, эрсдэлд нөхцөлд буй хүүхэд өсвөр үеийнхэн, шилжин суурьшигчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд, архаг хүнд өвчтэй хүмүүс, байгалийн гамшигт өртсөн олон нийт болон тэдний гэр бүл нь амьдралынхаа тодорхой үе шатуудад нийгмийн хамгааллын үйлчилгээг үр дүнтэй авах хэрэгцээ, шаардлагын дагуу 1900-аад оноос барууны орнуудад үүссэн нийгмийн ажлын салбар, нийгмийн ажилтны мэргэжил нь 1950-иад оноос эрчимтэй хөгжиж, гадаадын ихэнх орнууд Нийгмийн ажил үйлчилгээний тусгайлсан хууль гарган зохицуулж иржээ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийгмийн ажлын чиг үйлчилгээний зохицуулалт, чиглэл, хамрах хүрээ, үйл ажиллагааг харилцан адилгүй тодорхойлж, зөвхөн тухайн салбарын онцлогийг харгалзан тусгасан нь хэт явцуу бөгөөд салбар дундын хамтын уялдаагүй, мөн мэргэжлийн үйл ажиллагаа эрс ялгаатай байдлаар тодорхойлсон байна.

Хүний эрхийн үндэсний комиссын Монгол Улс дах хүний эрхийн төлөв байдлын 19, 20, 21, 22, 23 дахь илтгэлүүд Монгол Улсад нийгмийн ажил, үйлчилгээ нь олон улсын жишгээр мэргэжлийн түвшинд хүртээмжтэй бус байгаагаас нэн тэргүүнд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгэм, эдийн засгийн эрх зөрчигдөж, улмаар хүчирхийлэлд өртөх, амьдралын чанар буурах зэрэг дагалдах эрсдэл үүссээр байгаа талаар тусгагдсан байна.

Монгол Улсад нийгмийн ажлыг хүн амын, нийгмийн онцлог хэрэгцээнд тулгуурлан, бие даасан онол-арга зүйтэй шинжлэх ухаан, практик чиг баримжаатай ажил, мэргэжил болохынх нь хувьд улам хөгжүүлж, бусад салбарын нэгэн адил системтэй мэдлэг, хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэн, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйл, зарчимтай байх шалгууруудыг нь хүлээн зөвшөөрч нийгмийн хамгааллынхаа үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэх шаардлагатай.

Ингэснээр нийгмийн сэтгэл зүй, эрүүл мэндийн салбарынхаа үйлчилгээ, үйл ажиллагааг хүн амынхаа бодит хэрэгцээнд тулгуурлан хүргэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангуулах, халамж хамгаалал шаардлагатай бүлэгт хүрч очих, хүний суурь хэрэгцээг хангах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийн зорилт, нэр томьёо, зарчмыг тодорхойлсон.

Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг. Нийгмийн ажлын үйлчилгээ.

Тус бүлэгт нийгмийн ажлын үйлчилгээг хуульчилж өгсөн бөгөөд нийгмийн ажлын үйлчилгээний төрөл, нийгмийн ажлын шууд үйлчилгээний төрөл, нийгмийн ажлын үйлчилгээний үе шат, нийгмийн ажлын үйлчилгээний баримтжуулалт, нийгмийн ажлын шууд бус үйлчилгээ, түүний төрөл зэргийг тус тус зохицуулахаар оруулсан.

Дээрх зохицуулалт нь нийгмийн ажлын үйлчилгээ гэх нэгдсэн стандарт, ойлголтыг бий болгож байгаа бөгөөд ингэснээр нийгмийн ажилтнуудын хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн сатндарт, ойлголт бий болох боломжтой болж байгаа юм.

Монгол Улсын нийт 1,2 сая хүүхэд, тэдний 30 хувь нь бага орлоготой өрхийнх, 150000 гаруй ахмад настнууд хүнд нөхцөлд байгаа, 120000 орчим дэмжлэг хэрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Түүнчлэн Монгол Улсын нийт хүн амын 10.9% нь ахмад настан бөгөөд хоёр ахмад настны нэг нь сэтгэлзүйн эрүүл мэндийн тулгамдсан

асуудалтай; 39% нь 0-18 насны хүүхэд бөгөөд тодорхой хувь нь хүнд нөхцөлд амьдардаг; 3% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн; 30-40% нь ядуурлын түвшинд амьдарч байгаа нь нийгмийн ажлын хэрэгцээ дутагдаж байгааг цаашид шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн. Иймд тус бүлэгт нийгмийн ажлын үйлчилгээний төрөл хэлбэрийг тодорхойлсон.

Мөн хуулийн дараагийн бүлгүүдэд тусгагдсан нийгмийн ажилтаны мэргэжлийн нэгдсэн холбоо нь мэргэжлийн сургалтын хороогоор дамжуулж нийгмийн ажилтныг нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжүүлэхэд чадавхжуулах сургалтыг зохион байгуулах юм. Ингэснээр нийгмийн ажилтан нь өөрсдийн стандартыг баримталж, мэргэжлийн үйл ажиллагаандаа хандах, мөн нийгмийн ажил чанартай хүртээмжтэй болох боломж бий болж байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн улсад нийгмийн ажилтнууд лицензтэй, мэргэжлийн холбоотой, мэргэжлийн холбоо нь нийгмийн ажилтаны ёс зүй ур чадварыг хянадаг бөгөөд жилд 20-30 цагийн давтан сургалтанд хамруулдаг байна. Харин манай улсад ийм тогтолцоо байхгүй. Монголын уламжлалт “туслах” соёл нийгмийн ажлыг сайн дурын үндсэн үйл ажиллагаатай адилтгадаг бөгөөд энэ нь мэргэжлийн ач холбогдлыг бууруулдаг. Харин хуулийн төсөл батлагдснаар нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголт бий болж, дээрх хандлагыг зөв болгож залруулахад түлхэц болно гэж үзэж байна.

Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг. Нийгмийн ажлын үйлчилгээний оролцогч талууд.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилго 2-т “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.” гэж, мөн зорилгын 3 дах хэсэгт “Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.” гэж; мөн баримт бичгийн “2.2.10-д Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.”, 2.3.1-д “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ”, “2.3.3-д Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.”, “2.3.6-д Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” ... гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хоёр. Хүний хөгжлийн бодлогын 2.1.1-д Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого хэсэгт 2.1.3.8.Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр

эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална гэж заасан.

Олон улсын Нийгмийн ажлын холбоо Нийгмийн ажлын боловсрол ба сургалтын дэлхийн стандарт, MNS 5323-94 Нийгмийн ажлын дээд боловсролын Монгол Улсын стандарт, MNS 5852 Монгол улсын стандарт, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага стандарт болон Монголын Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байгаа хэдий ч салбар бүрд ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдлыг хангах, ажил үйлчилгээг нэгдсэн тогтолцоо, удирдлагаар хангах, хамтын ажиллагаа, оролцоог сайжруулахад нийтлэг мөрдөх эрх зүйн баримт бичиг байхгүй нь хуулийн төслийн тус бүлгийг боловсруулах үндэслэл болсон.

Тус бүлэгт нийгмийн ажил үйлчилгээний оролцогч субъектуудыг хуульчилж өгсөн бөгөөд Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Хоёр талт үндэсний хорооны чиг үүрэг, Нийгмийн ажил үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага, нийгмийн ажил үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд, мөн нийгмийн ажилтан нийгмийн ажлын шууд үйлчилгээ үзүүлж болох нөхцөл зэргийг тусгасан болно.

Монгол Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж хуульчилсаны дагуу нийгмийн ажлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, мөн нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвт тусган батлах зэрэг чиг үүргийг хуульчилсан.

Нийгмийн ажилтан нь мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад хамгийн их тохиолдож буй бэрхшээлийн нэг нь санхүүжилтийн дутагдал болох нь хуулийн төслийн тандан судалгаанаас харагдаж байна.

Монгол Улсын Засгийн газар нь Нийгмийн ажлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн ажлын үйлчилгээний бодлого хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх, мөн нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээ авах чиг үүргийг тусгасан. Уг заалтыг хуульчилсан шалтгаан нөхцөл нь нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжих боломжийг төрөөс дэмжих бодлогын шинж чанартай зохицуулалт юм.

Харин Монгол Улсад нийгмийн ажилтнууд төрийн албан хаагчдын дунджаас бага, улсын дундаж цалингийн тал хувьтай тэнцэх хэмжээний цалин авч байна. Цалингийн хэмжээ, урамшуулал, нэмэгдэл нь ажлын ачаалал болон гүйцэтгэлийн үр дүнтэй харилцан хамааралгүй бөгөөд нийгмийн ажилтан ажиллаж буй салбар бүрд ялгаатай байгаа нь хүний нөөцийн оновчтой хувилбар боловсруулах, нэгдсэн стратеги төлөвлөгөөгөөр ажиллуулахад хүндрэлтэй байна.

Иймд тус хуулийн төсөлд Хоёр талт үндэсний хороо нь Засгийн газар, Нийгмийн ажилтны холбооны төлөөлөл хоёр талт хороо байгуулах бөгөөд хоёр жил тутам зөвшилцөж төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдал, цалин хөлс, зэрэг дэвтэй холбоотой асуудлаар тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцэх шийдвэр гаргах зохицуулалтыг тусгалаа. Дээрх хоёр талт үндэсний

хороо нь төрийн байгууллагад ажиллаж буй нийгмийн ажилтнуудын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах чиг үүрэгтэй байна.

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллагын чиг үүргийг хуульчил өгсөн бөгөөд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага бүр нийгмийн ажилтны ажлын байранд мэргэжлийн нийгмийн ажилтныг шалгаруулж авах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн ажилтныг нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг хүлээхээр хуульчилсан. Ингэснээр төрийн байгууллагын уялдаа холбоо сайжрах ба үүнээс гадна хорих байгууллагын нийгмийн ажилтан болон бусад нийгмийн ажилтан нэгдсэн стандартаар нийгмийн ажил үйлчилгээг явуулах боломж бүрдэх юм.

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд. Уг хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан нийгмийн ажлын шууд үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд явуулж болохоор хуульчилж өгсөн бөгөөд нийгмийн ажилтаны мэргэжлийн нэгдсэн холбоо нь магадлан итгэмжлэлийг олгож байхаар зохицуулсан.

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг. Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбооны тухайд.

Дэлхий дахинд нийгмийн ажилтнууд нь эмч, багш, хуульч зэрэг бусад мэргэжилтнүүдийн нэгэн адил мэргэжлийн ур чадвараа гаргаж, ёс зүйн хэм хэмжээг баримталж, мэргэжлийн дадлага хийж, тусгай шалгалт өгч, зөвшөөрөл авч ажилладаг практик тогтолцоо хөгжсөн бөгөөд Их Британи, АНУ-д нийгмийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрч, тэдний цалинг улсын дундаж цалингийн түвшнээс дээгүүр тогтоосон байдаг.

Монгол улсад нийгмийн үйлчилгээний 5 салбарт нийт 2634 нийгмийн ажилтан ажиллаж байгаа боловч тус нийгмийн ажилтнуудын 30 хувийг нийгмийн ажлын мэргэжлийн зэрэгтэй, 70 хувийг бусад мэргэжлийн зэрэгтэй ажилтнууд бүрдүүлж байна. Ажлын байрны болон нийгмийн эрэлт хэрэгцээ өндөр байгаа хэдий ч дотоодын их, дээд сургуулиудыг жил бүр дунджаар 290 нийгмийн ажилтан мэргэжлээр төгсөж байна.

2020 оны мэргэжлээрээ ажилладаггүй төгсөгчдийн судалгаанд нийгмийн ажлын мэргэжлээр үргэлжлүүлэн ажиллахгүй байгаа шалтгааныг ажлын ачаалал орчин нөхцөл маш хүнд боловч ажлын цалин урамшуулал бага, ажил үүрэг тодорхойгүй, удирдлага мэргэжлийн онцлогийг ойлгодоггүй, мэргэжлийн ахиц дэвшил тодорхойгүй гэж дүгнэсэн байна.

Нийгмийн ажлын мэргэжлийн үнэт зүйл, ёс зүйн, стандартын талаарх нэгдмэл ойлголт их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр болон бусад шатны урт болон богино хугацааны хөтөлбөрүүдэд харилцан адилгүй туссан байх тул нэгдсэн мэргэжлийн үнэт зүйлийг тодорхойлох хөтөлбөрийг боловсруулах тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн нийгмийн завсрын бүлгүүд болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд, эрсдэлт нөхцөлд бага насны хүүхдүүдийг дам эрсдэлээс урьдчилан сэргийлэх нийгмийн тогтолцоо бүрдээгүй байна.

Иймд дээрх хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийг боловсруулах замаар нийгмийн ажлын салбар болон салбарын мэргэжилтнүүдэд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Тус бүлгээр нийгмийн ажилтаны мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг дэлгэрэнгүй зохицуулж өгсөн бөгөөд нийгмийн ажилтаны мэргэжлийн нэгдсэн холбоо, гишүүнчлэл, чиг үүрэг, Нийгмийн ажилтаны их хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, мэргэжлийн хорооны бүтэц, чиш үүрэг, зохион байгуулалт, хяналтын зөвлөл, ажлын алба, нийгмийн ажилтаныг бүртгэх, хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх түдгэлзүүлэх, мэргээх, хүчингүй болгох зэрэг эрх зүйн харилцааг зохицуулахаар хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлаас 2024 онд батлагдсан мэргэжлийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа зохицуулах бөгөөд зарим бүтэц болон тэдгээрийн чиг үүргийг нэмэлтээр хуулийн төсөлд шигтгэн тусгасан.

Хуулийн төслийн Тавдугаар бүлэг. Нийгмийн ажилтны эрх зүйн байдал, баталгаа.

Монгол Улсад нийт 758 хүүхэд хамгааллын хамтарсан баг 6318 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Хамтарсан багийн гишүүдийн 699 нь нийгмийн ажилтан бөгөөд тус нийгмийн ажилтнуудын 419 нь нийгмийн ажлын мэргэжлийн бус ажилтнууд ажиллаж байна. Түүнчлэн нийслэлийн хэмжээнд 204 хүүхэд хамгааллын хамтарсан баг 1176 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Түүнээс 396 гишүүн нь нийгмийн ажлын мэргэжилтэн байх ёстой боловч бодит байдал дээр 171 нийгмийн ажилтан ажиллаж байна. Дээрх судалгаанаас үзвэл, ажиллах хүчний нөөц боломж сул, ажиллаж байгаа одоогийн ажиллах хүч нь байх ёстой орон тооноос 20-30 орчим хувиар бага боловч ажилтнуудын 60 орчим хувь нь мэргэжлийн бус ажилтнууд байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль тусгагдсан хамтарсан багийн нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд заасан олон чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд 20 гаруй төрлийн судалгаа хөтөлж, хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчид сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, хохирогчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээнд хамруулах зэргээр тус багийн нийт үйл ажиллагааны 80-90 хувийг дангаар гүйцэтгэж байгаа боловч цалин урамшууллын хувьд Үндэсний статистикийн хорооноос тодорхойлсон дундаж цалингаас 29-өөс 59 хүртэл хувиар бага байна.

Бага насны хүүхэд болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай гэр бүл хувь хүн, архаг хүнд өвчтэй хүнтэй ажиллах нийгмийн ажилтны нарийвчилсан үйлчилгээний стандарт, аргагүй тодорхойгүй байна. Тухайлбал хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх арга хэмжээг сургуулийн нийгмийн ажилтан, багш нар хувийн туршлага арга зүйд үндэслэн шийдвэрлэж байгаа нь зарим тохиолдолд хүртээмжгүй оновчгүй эсвэл тохиромжгүй байна.

Тус бүлэгт нийгмийн ажилтны эрх зүйн байдал, баталгааг зохицуулсан бөгөөд нийгмийн ажилтны нийтлэг эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох зүйл, мэрэгжлийн удирдлага, үргэлжилсэн сургалт, мэргэшсэн нийгмийн ажилтны талаар зохицуулж өгсөн.

Хуулийн төслийн Зургадугаар бүлэг. Мэдээллийн сан.

Монгол улсад мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээ авсан иргэд, гэр бүл, олон нийтийн талаарх ахиц дэвшил, өөрчлөлт болон бие даасан байдлын өсөлтийг харуулсан эргэх холбоо бүхий мэдээллийн нэгдсэн сан байхгүй. Үйлчилгээ үр дүнтэй залгамж холбоотой хүртээмжтэй байхын тулд нийгмийн ажлын бусад мэргэжилтнүүдтэй хамтрах бодит мэдээллийн санг байгуулах шаардлагатай. Мөн үйлчилгээ үр дүнтэй эсэхийг бүх шатанд үнэлэх, дахин төлөвлөх үйл ажиллагаа хийгдэхгүй байгаа нь нэгдсэн мэдээллийн сан байгуулагдаагүйгээс шалтгаалж байна.

Тус бүлгээр нийгмийн ажил үйлчилгээний мэдээллийн санг зохицуулсан бөгөөд мэдээллийн сан бүрдүүлэх ерөнхий шаардлага, сангийн үйл ажиллагааг хангах байгууллага, мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, санхүүжилт гэх хэсгийг тус тус зохицуулж өгсөн.

Долоодугаар бүлэг. Бусад зүйл гэх хэсэг.

Уг бүлэгт бусад зүйл хэсгийг зохицуулсан бөгөөд нийгмийн ажлын хууль тогтоомжийг зөрчигчөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох огноог тус тус хуульчилж өгсөн болно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, салбар хоорондын уялдаатай нийгмийн ажлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай, тасралтгүй хүргэх тогтолцоог бүрдүүлэх, хүний бие даан шийдвэр гаргах чадварыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн ажлын хууль тогтоомж

2.1.Нийгмийн ажлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын хууль тогтоомжид нийгмийн ажлын талаар тусгайлан заасан бол нийгмийн ажлын хууль тогтоомжид хамаарна.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин сууж байгаа иргэн Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын иргэнд энэ хуульд заасан нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлнэ.

3.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа харьяалалгүй энэ хуульд заасан нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлж болно.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно.

4.1.1."нийгмийн ажил" гэж нийгмийн хөгжил, өөрчлөлт, нийгмийн эв нэгдлийг дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг хангах, тэднийг чадавхжуулахад чиглэсэн мэргэжлийн арга зүй бүхий цогц үйл ажиллагаа;

4.1.2."нийгмийн ажлын үйлчилгээ" гэж нийгмийн ажилтнаар дамжуулан хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд үзүүлж буй энэ хуульд заасан тусламж, дэмжлэг, зөвлөгөө, хамгааллын багц үйлчилгээг;

4.1.3."нийгмийн ажилтан" гэж Нийгмийн ажлын үйлчилгээг хүргэхэд шаардлагатай шинжлэх ухааны мэдлэг, ур чадвар, хандлагатай бүхий дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтнийг;

4.1.4."нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоо" гэж /цаашид "Нийгмийн ажилтны холбоо" гэх/ гэж нийгмийн ажилтны мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, нийгмийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой, гишүүнчлэл бүхий өөрийн удирдлагатай, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг.

5 дугаар зүйл.Нийгмийн ажлын зарчим

5.1.Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн, чанартай, хүртээмжтэй, нотолгоонд суурилсан байх;

5.2.Хүн ам, зорилтот бүлгийн тандалт судалгаа, үнэлгээнд суурилсан, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх

5.3.Нэгдсэн арга зүй, нийгмийн шинжлэх ухааны салбарын ололт амжилтад нийцсэн байх;

5.4.Салбар дундын уялдааг хангасан, олон талт хамтын ажиллагаа, олон мэргэжлийн багаар үйлчилгээг үзүүлэх;

5.5.Хүн ам, зорилтот бүлэг, үйлчлүүлэгчийн оролцоог нэмэгдүүлж, бие даан шийдвэр гаргах чадварыг дэмжих;

5.6.Хүний эрхэм чанар, нэр төрийг хүндэтгэж, хүний хувийн, эмзэг мэдээллийг зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах;

5.7.Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг тогтоож, мэргэжлийн тасралтгүй хөгжил, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, тасралтгүй хөгжүүлэх

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

6 дугаар зүйл.Нийгмийн ажлын үйлчилгээний төрөл

6.1.Нийгмийн ажлын үйлчилгээ нь шууд болон шууд бус төрөлтэй байна.

6.2.Нийгмийн ажлын шууд үйлчилгээ нь нийгмийн ажилтан хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй шууд харилцаж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас бүрдэнэ.

6.3.Нийгмийн ажлын шууд бус үйлчилгээ нь нийгмийн ажлын бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, нийгмийн судалгаа хийх, бодлогын нөлөөлөл үзүүлэх, олон улсын нийгмийн ажилд оролцох замаар нийгмийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанаас бүрдэнэ.

7 дугаар зүйл.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний төрөл

7.1.Нийгмийн ажлын шууд үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

7.1.1.хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ;

7.1.2.амьдралын хүнд нөхцөлөөс гарахад чиглэсэн дэмжлэг, туслалцаа;

7.1.3.эрсдэлт бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ;

7.1.4.олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа;

7.1.5.нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн дадал, зуршлын зөвлөгөө;

7.1.6.нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх;

7.1.7.төлөөлөл хэрэгжүүлэх;

7.1.8.тусламж үйлчилгээний зохицуулалт.

8 дугаар зүйл.Хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ

8.1.Хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэхэд дэмжих, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хамаарна.

9 дүгээр зүйл.Амьдралын хүнд нөхцөлөөс гарахад чиглэсэн дэмжлэг

9.1.Нийгмийн халамж, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн ажилтан, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд үзүүлнэ.

9.2.Нийгмийн ажилтан нь амьдралын хүнд нөхцөлөөс гарахад чиглэсэн дэмжлэг туслалцааг Нийгмийн халамжийн тухай хуулийн 13, 17, 18 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.

10 дугаар зүйл.Эрсдэлт бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ

10.1.Нийгмийн халамжийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Ахмад настны эрхийн тухай хуульд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүн, тодорхой бүлэгт нийгмийн хамгааллын үйлчилгээг тухайн хуульд заасны дагуу үзүүлнэ.

10.2.Эрүүл мэнд, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн эмзэг байдлаас шалтгаалан эрсдэлт нөхцөлд байгаа хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулна.

10.3.Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, тахал, гоц халдварт болон олон улсын хөл хориот өвчин гарсан үед нийгмийн ажлын үйлчилгээг нэрвэгдэгсдэд болон тухайн бүсийн зорилтот бүлэгт саадгүй, тасралтгүй, шуурхай үзүүлнэ.

11 дүгээр зүйл.Олон нийтийн оролцоог дэмжих, соён гэгээрүүлэх арга хэмжээ

11.1.Хүний сайн сайхан байдал, нийгэмд хэвийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэнд, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн обьектив болон субъектив аливаа эрсдэлийг бууруулах нөлөөллийн цогц арга хэмжээг соён гэгээрүүлэх арга хэмжээ гэнэ.

11.2.Олон нийтийн оролцоог дэмжих, соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.нийгмийн ажлын үйлчилгээ шаардагдах хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийг тодорхойлох;

11.2.2.тэдний онцлог, ялгаатай байдал, зан үйл, дадалд суурилж арга хэмжээг тодорхойлох;

11.2.3. мэдэгдэл, зөвлөмж, сургалт сурталчилгааг хийх

12 дугаар зүйл.Нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө

12.1.Хүний сэтгэл санаа, эрүүл мэндийн дадал зуршил, нийгмийн харилцааг дэмжих, хэвийн байдлаа хадгалахад туслах, сэтгэл зүйн анхны тусламж, нийгмийн дэмжлэгийг үзүүлнэ.

12.2.Нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөний хэлбэрээр үзүүлнэ.

13 дугаар зүйл.Нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх

13.1.Хувь хүн, түүний гэр бүлийн гишүүнд нийгэмд хэвийн ажиллаж, амьдрахад дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжилтэнд зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлнэ.

13.2.Энэ хуульд заасан нийгмийн ажлын үйлчилгээг мэргэшсэн байгууллага хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр бол үйлчлүүлэгчийг тухайн байгууллагад шилжүүлэн хүргэнэ.

14 дүгээр зүйл.Төлөөлөл хэрэгжүүлэх

14.1.Хүн өөрийн эрүүл мэнд, сэтгэл зүй, нас, хөгжлийн бэрхшээл, орон зай болон цаг хугацааны нөхцөл байдлын улмаас өөрийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, нийгмийн ажлын үйлчилгээг авах боломжгүй эсхүл хязгаарлагдсан тохиолдолд нийгмийн ажилтан нь тухайн хүний өмнөөс төлөөлөл хэрэгжүүлнэ.

14.2.Нийгмийн ажилтан нь хууль тогтоомжид заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлэхдээ үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлж оролцоно.

15 дугаар зүйл.Тусламж, үйлчилгээний зохицуулалт

15.1.Хууль тогтоомжид заасан тусламж үйлчилгээ, энэ хуульд заасан нийгмийн ажлын шууд үйлчилгээний төрлийг сонгох, зохицуулах, олон мэргэжлийн багийн менежмент хийх үйлчилгээг нийгмийн ажилтан хариуцна.

15.2.Тусламж үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ кейс менежмент, төлөвлөлтийг хийнэ.

16 дугаар зүйл.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний үе шат

16.1.Нийгмийн ажлын шууд үйлчилгээ дараах үе шаттай байна.Үүнд:

- 16.1.1.Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох;
- 16.1.2.үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг үнэлэх;
- 16.1.3.нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх;
- 16.1.4.нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжүүлэх;
- 16.1.5.нийгмийн ажлын үйлчилгээг үнэлэх;
- 16.1.6.нийгмийн ажлын үйлчилгээг хаах.

16.2.Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат, хэрэгжүүлэх үйл ажиллагааг стандартаар тогтоох бөгөөд уг стандартыг Нийгмийн ажилтны холбоо, стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулна.

16.3.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд олон улсын байгууллагаас баталсан, нийтээр хүлээн зөвшөөрсөн нийгмийн ажлын үйлчилгээний стандарт, удирдамж, зөвлөмжийг хэрэглэж болно.

16.4.Энэ зүйлд заасан гадаад улсын болон олон улсын стандартыг хэрэглэхээр бол Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны үндэсний стандартаар бүртгүүлнэ.

17 дугаар зүйл.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний баримтжуулалт

17.1.Нийгмийн ажилтан нь шууд үйлчилгээний тэмдэглэлийг хууль, тогтоомжид заасан стандартад нийцүүлэн цаасан болон цахим хэлбэрээр хөтөлж, нийгмийн ажил, үйлчилгээний нийтлэг шаардлага стандартын дагуу хадгалах бөгөөд хуульд заасан тохиолдолд холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид танилцуулна.

17.2.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний хүрээнд баримтжуулсан мэдээллийг энэ хуульд заасан мэдээллийн санд байршуулж, үйл ажиллагаанд ашиглана.

18 дугаар зүйл.Нийгмийн шууд бус үйлчилгээ

18.1.Нийгмийн шууд бус үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

18.1.1.олон улсын нийгмийн ажил;
18.1.2.нийгмийн ажлын бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх
үнэлэх;
18.1.3.нийгмийн ажлын судалгаа;
18.1.4.нийгмийн бодлогын нөлөөлөл;

18.2.Нийгмийн ажилтны мэргэжлийн зэрэг, дэв тогтоох, мэргэшсэн нийгмийн ажилтныг тодорхойлоход энэ зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлчилгээний туршлага, үзүүлэлтийг харгалзан үзнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

19 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

19.1.Улсын их хурал нь нийгмийн ажлын үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.нийгмийн ажлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
19.1.2.нийгмийн ажлын үйлчилгээний талаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

19.1.3.нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган батлах;

19.1.4. хуульд заасан бусад.

20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

20.1.Засгийн газар нь нийгмийн ажлын үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.нийгмийн ажил үйлчилгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

20.2.1.нийгмийн ажлын үйлчилгээний бодлого, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх;

20.3.1.нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах;

20.4.1.хуульд заасан бусад.

21 дүгээр зүйл.Хоёр талт үндэсний хороо

21.1.Засгийн газар, Нийгмийн ажилтны холбооны төлөөлөл хоёр талт хороо байгуулж, хоёр жил тутам зөвшилцөж төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдал, цалин хөлс, зэрэг дэвтэй холбоотой асуудлаар тогтоол шийдвэр гаргана.

21.2.Хоёр талт хороо тэдгээрийн гишүүд нь бие дааж, хараат бусаар ажиллана.

21.3.Үндэсний хорооны дүрмийг Засгийн газар батална.

21.4.Хоёр талт үндэсний хороо ажлын албатай байна. Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

21.5.Үндэсний хороо дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ:

21.5.1.төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтны цалин хөлстэй холбоотой асуудлаар тогтоол гаргах;

21.5.2.нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах;

21.5.3.нийгмийн ажлын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах, хууль тогтоомжийн төсөлтэй урьдчилан танилцах, батлагдахаас өмнө саналаа хүргүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх;

21.5.4.энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд холбогдох дүрэм, аргачлал батлан мөрдүүлэх, тогтоол батлах;

21.5.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

22 дугаар зүйл.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага

22.1.Нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг тухайн салбарын хуулиар эрх олгосон төрийн байгууллага, түүний ажилтан нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ.

22.2.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага нь үйлчлүүлэгчид нийгмийн ажлын шууд үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтантай байх бөгөөд төрийн байгууллагад ажиллах нийгмийн ажилтны жишиг тоог хүн амын нягтрал, шилжилт хөдөлгөөн, эрсдэлт бүлгийн хүн ам, үйлчлүүлэгчийн тоо, салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно.

22.3.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага бүр нийгмийн ажилтны ажлын байранд мэргэжлийн нийгмийн ажилтныг шалгаруулж авах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн ажилтныг нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагаар хангана.

22.4.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага нь нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх бодлого, чиглэл, санхүү, хүний нөөцийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангана.

22.5.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага нь үзүүлж буй нийгмийн ажлын шууд үйлчилгээнийхээ талаар бүртгэл хийж, энэ хуульд заасан мэдээллийн санд бүртгүүлнэ.

23 дугаар зүйл.Нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд

23.1.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхээр дүрэмдээ заасан мэргэшсэн хуулийн этгээд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлнэ.

23.2.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан нийгмийн ажлын шууд үйлчилгээг хуулийн этгээд бие даан үзүүлж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан тохиолдолд магадлан итгэмжлэгдэнэ. Үүнд:

23.2.1.хоёроос доошгүй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтантай байх;

23.2.2.нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

23.2.3.үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх;

23.2.4.хүсэлт гаргагч хуулийн этгээд нь дотоод журамдаа нийгмийн ажлын үйлчилгээний үндэсний стандартад нийцсэн аргачлалыг тусгасан байх;

23.2.5.хүсэлт гаргагч хуулийн этгээд нь өөрийн дотоод журамдаа санхүүгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах.

23.3.Нийгмийн ажил үйлчилгээг бие даан эрхлэх хуулийн этгээд энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл дараах баримт бичгийг бүрдүүлэн Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанд хүргүүлнэ:

23.3.1.нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн гэрчилгээ;

23.3.2.хуулийн этгээдийн дүрэм, дотоод журам

23.3.3.Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан шаардлагыг хангасан баримт бичиг.

23.4.Хорооны ажлын алба энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3-т заасан хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянаж, шаардлага хангасан хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх саналыг Нийгмийн ажилтны холбооны Мэргэжлийн Хороонд хүргүүлнэ.

23.5.Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанаас энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-д заасан саналыг үндэслэн Мэргэжлийн хороо нийгмийн ажлын үйлчилгээ явуулах хуулийн этгээдийг 3 жилийн хугацаагаар магадлан итгэмжилнэ.

23.6.Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар 15 хоногийн дотор Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанд мэдэгдэж бүртгүүлнэ.

24 дүгээр зүйл.Нийгмийн ажилтан нийгмийн ажлын шууд үйлчилгээ эрхлэх

24.1.Энэ хуульд заасан нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын шууд үйлчилгээг Нийгмийн ажилтны холбооны нэгдсэн бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр үзүүлэх ба нийгмийн ажлын мэргэжлийн дүрмийг баримтална.

24.2.Нийгмийн ажилтны холбоо нь нийгмийн ажилтныг мэргэжлийн чиглэлээр бүртгэж, чадавхижуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НИЙГМИЙН АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО

25 дугаар зүйл. Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоо, түүний гишүүнчлэл

25.1. Нийгмийн ажилтны холбооны үйл ажиллагааг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлно.

25.2. Нийгмийн ажилтны холбоо нийгмийн ажилтны мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, нийгмийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

25.3. Энэ хуульд заасан нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийгмийн ажилтан нь нийгмийн ажилтны холбооны гишүүнчлэлтэй байх бөгөөд нийгмийн ажилтан мэргэжилтэй этгээд нь гишүүн байж болно.

25.4. Нийгмийн ажилтны холбооны эрх барих дээд байгууллага нь нийт гишүүдийн их хурал байна.

25.5. Нийгмийн ажилтны анхдугаар их хурлаар Нийгмийн ажилтны холбоог байгуулах бөгөөд Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулна.

25.6. Нийгмийн ажилтны холбоо нь Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ажлын алба, Мэргэжлийн хороо болон бусад төрлийн хороодтой байна.

25.7. Нийгмийн ажилтнууд сайн дураараа нэгдэж байгуулсан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд нь нийгмийн ажилтны холбооны үйл ажиллагаанд эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар оролцож болно.

26 дугаар зүйл. Нийгмийн ажилтны холбооны чиг үүрэг

26.1. Нийгмийн ажилтны холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 26.1.1. нийгмийн ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 26.1.2. нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм батлах, сахиулах;
- 26.1.3. мэргэжлийн хороо байгуулан ажиллуулах;
- 26.1.4. нийгмийн ажилтны үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох;
- 26.1.5. нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх;
- 26.1.6. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх;
- 26.1.7. нийгмийн ажлын шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, судалгаа шинжилгээ хийх;

26.1.8. мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, нийгмийн ажилтны нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа зохион байгуулах;

26.1.9. нийгмийн ажилтны нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журмыг батлах.

27 дугаар зүйл. Нийгмийн ажилтны Их хурал

27.1. Нийгмийн ажилтны Их хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

27.1.1. Нийгмийн ажилтны холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах;

27.1.2. Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;

27.1.3. Нийгмийн ажилтны Удирдах зөвлөлийн гишүүдийг батламжлах, чөлөөлөх;

27.1.4. Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулж, бүрэлдэхүүнийг батламжлах, чөлөөлөх;

27.1.5. Нийгмийн ажилтны холбооны Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, зөвлөмж өгөх;

27.1.6. Нийгмийн ажилтны холбооны гишүүний татварын хэмжээг тогтоох;

27.1.7. Нийгмийн ажилтны холбооны дүрмээр тогтоосон бусад чиг үүрэг.

27.2. Нийгмийн ажилтны Их хурлын ээлжит хуралдаан гурван жилд нэг удаа хуралдах бөгөөд Нийгмийн ажилтны их хурал хуралдааныг нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч даргална.

27.3. Нийгмийн ажилтны Их хурлын төлөөлөгчдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.

27.4. Нийгмийн ажилтны Их хуралд оролцох нийгмийн ажилтны төлөөлөгчдийг сонгох журмыг Нийгмийн ажилтны холбооны дүрмээр тогтооно.

27.5. Нийгмийн ажилтны Их хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хуралдаан эхлэхээс 90 хоногийн өмнө Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

27.6. Нийгмийн ажилтны их хурал энэ хуулийн 28.1.1, 28.1.2, 28.1.6-д заасан асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн энгийн олонхын саналаар, бусад асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар тус тус шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана.

27.7.Нийгмийн ажилтны их хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар Нийгмийн ажилтны их хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа бичгээр, эсхүл цахим хэлбэрээр битүүмжлэн ирүүлж болно.

27.8.Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-д заасны дагуу ирсэн саналыг хэлэлцэх журмыг хуралдааны дэгээр зохицуулна.

28 дугаар зүйл.Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч

28.1.Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч нь нийгмийн ажилтны хувьд нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, манлайлагч байна.

28.2.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг улируулан сонгохгүй.

28.3.Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.3.1.нийгмийн ажилтны холбооны зөвлөлтэй зөвшилцөн Их хурлыг зарлан хуралдуулах;

28.3.2.нийгмийн ажилтны холбооны зөвлөлийн хуралдааныг даргалах;

28.3.3.холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

28.3.4.холбооны зөвлөлд Нийгмийн ажилтны холбооны ажлын албаны даргад нэр дэвшүүлэх;

28.3.5.энэ хуулиар болон Нийгмийн ажилтны холбооны дүрмээр олгосон бусад бүрэн эрх.

28.4.Ерөнхийлөгч нь Нийгмийн ажилтны холбооны Ажлын албаны үйл ажиллагаанд оролцохгүй.

29 дүгээр зүйл.Нийгмийн ажилтны холбооны Удирдах зөвлөл

29.1.Нийгмийн ажилтны холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, бодлогыг тодорхойлох чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага байна.

29.2.Нийгмийн ажилтны холбооны Удирдах зөвлөл нь 15-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүд хороодын төлөөлөл байна.

29.3.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно.

29.4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно.

29.5.Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

29.6.Энэ хуулийн 30.2-т заасан гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр удирдах зөвлөлийн хурал хүчинтэй болох бөгөөд хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар шийдвэр батлагдана.

30 дугаар зүйл.Мэргэжлийн хорооны бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг

30.1.Нийгмийн ажилтны холбооны дэргэд орон тооны Мэргэжлийн хороо /цаашид “Хороо” гэх/ ажиллана.

30.2.Мэргэжлийн хорооны гишүүдийг Нийгмийн ажилтны холбооны Их хурлаас сонгоно.

30.3.Хороо нь есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүдийн олонхын саналаар хорооны даргыг дотроосоо сонгоно.

30.4.Хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.

30.5.Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь ээлжит болон ээлжит бус хуралдаан байна.

30.6.Хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

30.7.Ээлжит бус хурлыг хорооны гишүүдийн саналыг үндэслэн хорооны даргын шийдвэрээр хуралдуулж болно.

30.8.Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болно.

30.9. Мэргэжлийн Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

30.9.1.нийгмийн ажилтны нэгдсэн бүртгэл хөтлөх;

30.9.2.хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, бүртгэх;

30.9.3.нийгмийн ажлын үйлчилгээний магадлан итгэмжлэлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, түүнд хамаарах журам батлах, хэрэгжүүлэх;

30.9.4.нийгмийн ажилтнуудыг сургах, давтан сургах сургалт зохион байгуулах;

30.9.5.өөрийн эрх хэмжээний хүрээнд холбогдох стандартыг мөрдүүлэх.

31 дүгээр зүйл.Мэргэжлийн хариуцлагын хорооны бүтэц, зохион байгуулалт

31.1.Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон нийгмийн ажилтны ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох,нийгмийн ажилтны ёс зүйн асуудлаар судалгаа хийх зэрэг ажлыг нийгмийн холбооны нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо /цаашид "Ёс зүйн хороо" гэх/ зохион байгуулна.

31.2. Ёс зүйн хороонд нийгмийн ажилтны ёс зүйн асуудлаар судалгаа хийдэг, нийгмийн ажилтны мэргэжлийн сургуульд тухайн чиглэлээр хичээл заадаг профессор болон нийгмийн ажилтны ёс зүйн боловсролыг дээшлүүлэх, ёс зүйн хувьд нийгмийн ажилтныг манлайлах эрмэлзлэлтэй нийгмийн ажилтнууд сайн дураар нэгдэн ажиллана.

31.3. Ёс зүйн хорооны гишүүн нь Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа нийгмийн ажилтны зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно.

31.4. Ёс зүйн хороо Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал болон нийгмийн ажилтан мэргэжлийн дүрмийн хэрэгжилтийн тайланг Зөвлөлд танилцуулна.

31.5. Мэргэжлийн хариуцлагын хороо нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан мэргэжлийн хорооны журмын нэгэн адил ажиллана.

31.6. Мэргэжлийн хариуцлагын Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

31.6.1. нийгмийн ажлын үйлчилгээний үйл ажиллагаанд гаргасан гомдлыг шийдвэрлэх;

31.6.2. нийгмийн ажилтны мэргэжлийн болон ёс зүйн дүрэм зөрчсөн талаар гаргасан гомдлыг шийдвэрлэх;

31.6.3. нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

32 дугаар зүйл. Хяналтын зөвлөл

32.1. Хяналтын зөвлөл нь Нийгмийн ажилтны холбооны эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

32.2. Хяналтын зөвлөл нь Нийгмийн ажилтнаас бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно.

32.3. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг холбооны дүрмээр батална.

33 дугаар зүйл. Ажлын алба

33.1. Нийгмийн ажилтны холбооны Үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий Ажлын албатай байна.

33.2. Нийгмийн ажилтны холбооны ажлын алба холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Мэргэжлийн хороог үйл ажиллагаа явуулах боломжоор хангана.

33.3. Хорооны ажлын алба энэ хуулийн нийгмийн ажилтныг бүртгэж, аль нэг салбараар мэргэшсэн талаарх нийтэд нээлттэй зарлана.

33.4.Нийгмийн ажилтны ёс зүйн талаар гаргасан гомдол болон хуулийн этгээд үйл ажиллагаанд гаргасан гомдлыг Хорооны ажлын албанд гаргах бөгөөд ажлын алба гомдлыг хүлээн авч бүртгэн, Мэргэжлийн хорооны аль нэг гишүүнд санамсаргүй байдлаар хуваарилна.

33.5.Холбооны Ажлын алба нийгмийн ажилтнуудын нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

33.6.Хорооны гишүүн гомдлыг хүлээн авч, гомдолтой холбоотой нотлох баримтыг цуглуулж шалгаад гомдлыг хэлэлцэх үндэслэлгүй гэж үзвэл энэ талаар гомдол гаргагчид хариу мэдэгдэх бөгөөд гомдлыг хэлэлцэх үндэслэлтэй гэж үзвэл үргэлжлүүлэн шалгаж, хорооны нийт гишүүдэд танилцуулж шийдвэрлэнэ.

33.7.Хорооны нийт гишүүд гомдлыг хэлэлцээд дараах тогтоол гаргана:

33.7.1.нийгмийн ажилтан, хуулийн этгээдэд сануулах;

33.7.2.нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийг түр хугацаагаар хязгаарлах;

33.7.3.хуулийн этгээдийг магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох.

34 дүгээр зүйл.Нийгмийн ажилтныг бүртгэх, хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх

34.1.Энэ хуульд заасан шаардлага хангасан нийгмийн ажилтан бүртгүүлэх хүсэлтээ холбогдох баримтын хамт Мэргэжлийн Хороонд гаргана.

34.2.Хороо энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д заасан хүсэлт, холбогдох баримтыг ажлын 10 хоногийн дотор шалгаж шаардлага хангасан тохиолдолд нийгмийн ажилтныг мэргэжлийн чиглэлээр ангилж, бүртгэнэ.

34.3.Нийгмийн ажилтан нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх явцад мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан бол зөрчлийн шинж байдал, маргааны талуудад учруулсан хор уршиг, үр дагаврыг харгалзан мэргэжлийн дүрэмд заасан хариуцлагыг оногдуулна.

34.5.Хороо нь дараах үндэслэлээр нийгмийн ажилтныг нэгдсэн бүртгэхээс татгалзана:

34.5.1.нийгмийн ажилтны эрхийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

34.5.2.нийгмийн ажилтны гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

34.5.3.нийгмийн ажилтны иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

34.5.4.нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан мэдээллийг задруулсан;

34.5.5.хуульд заасан бусад.

35.6.Хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх асуудлыг Мэргэжлийн хорооны дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, БАТАЛГАА

36 дугаар зүйл.Нийгмийн ажилтан

36.1.Нийгмийн ажилтан нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан нийгмийн ажлын шууд болон шууд бус үйлчилгээг үзүүлэх этгээдийг хэлнэ.

36.2.Нийгмийн ажилтан хууль тогтоомжид заасан эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр чадавхиж, энэ хуульд заасны дагуу нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ.

37 дугаар зүйл.Нийгмийн ажилтны нийтлэг эрх, үүрэг

37.1. Нийгмийн ажилтан дараах нийтлэг эрхийг эдэлнэ:

37.1.1.нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;

37.1.2.хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах нөхцөл, баталгааг бүрдүүлэх, түүнийг сайжруулахыг шаардах;

37.1.3.нийгмийн ажилтны эрх, хууль ёсны сонирхлоо хамгаалуулахаар эвлэлдэн нэгдэх;

37.1.4.төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах;

37.1.6.хуульд заасан бусад эрх.

37.2. Нийгмийн ажилтан нь дараах үүргийг хүлээнэ:

37.2.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт болон Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрмийг мөрдөх;

37.2.2.үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх;

37.2.3.үйлчлүүлэгчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг нотолгоонд тулгуурлан тодорхойлох, үр нөлөөг судлах;

37.2.4.нийгмийн ажилтны үйл ажиллагаа, шийдвэр хуульд нийцсэн байх;

37.2.5.мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан мэдээлэл болон үйлчлүүлэгчийн нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх;

37.2.6.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу нийгмийн ажлын үйлчилгээг хараат бусаар үзүүлэх;

37.2.7.өөрийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлэх, мэргэжлийн чиглэлээр багц цагийн сургалтад хамрагдах;

37.2.8.мэргэжлийн үйл ажиллагаагаа ажил олгогчийн өмнө, мэргэжлийн ёс зүйн хариуцлагаа Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоонд хариуцан тайлагнах;

37.2.9.хуульд заасан тохиолдолд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах;

37.2.10.хууль тогтоомжид заасан тохиолдолд Нийгмийн ажилтны холбооны гишүүнчлэлийн хураамж төлөх;

37.2.11.хуульд заасан бусад үүрэг.

38 дугаар зүйл.Нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм

38.1.нийгмийн ажилтан нь энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм /цаашид "Нийгмийн ажлын мэргэжлийн дүрэм" гэх/-тэй байна.

38.2.нийгмийн ажлын мэргэжлийн дүрмийг Нийгмийн ажилтны холбооны Их хурлаар батална.

39 дүгээр зүйл.Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох зүйл.

39.1.Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

39.1.1.улс төрийн үйл ажиллагаа явуулах, улс төрийн намын гишүүнчлэлтэй байх;

39.1.2.хуульд зааснаас бусад тохиолдолд үйлчлүүлэгчийн хувийн нууцыг задруулах;

39.1.3.нийгмийн ажилтны нэрийг өөр зорилгоор ашиглах;

39.1.4.хувийн давуу байдлаа ашиглах, харилцаа тогтоох, эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах, авлига авах, ялгаварлан гадуурхаж харилцах зэрэг ашиг сонирхлын зөрчил гаргах;

39.1.5.Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, хууль ёсны зарчмын эсрэг үйл ажиллагаа явуулах;

39.1.6.үйлчлүүлэгчийнхээ болон нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд нь өртөж байгаа этгээдийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн болон бусад этгээдийн нэрээр худалдан авах, эсхүл өөр бусад аргаар олж авах, эзэмших, гэмтээж сүйтгэх.

40 дүгээр зүйл.Мэргэжлийн удирдлага, үргэлжилсэн сургалт

40.1.нийгмийн ажилтан нь мэргэжлийн удирдлагаар хангагдаж, үргэлжилсэн сургалтад хамрагдана.

40.2.Мэргэжлийн удирдлагаар хангах, үргэлжилсэн сургалт зохион байгуулах журмыг Нийгмийн ажилтны холбооны Мэргэжлийн хороо баталж, хэрэгжүүлнэ.

41 дүгээр зүйл.Мэргэшсэн нийгмийн ажилтан

41.1.Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу болон нийгмийн ажлын салбар, тодорхой чиглэлээр нийгмийн ажилтан мэргэшин ажиллана.

15.2.Тусламж үйлчилгээний үйлчилгээний зохихуулалтыг хэрэгжүүлэхдээ кейс менежмент, төлөвлөлтийг хийнэ.	Холт Интернэшнл байгууллага 15.2-ийн "кейс менежмент" гэсэн хуулийн нэр томъёоны тайлбар оруулах.
---	--

16 дугаар зүйл.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний үе шат

16.1.Нийгмийн ажлын шууд үйлчилгээ дараах үе шаттай байна: 16.1.1.Үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоох; 16.1.2.үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг үнэлэх; 16.1.3.нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх; 16.1.4.нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжүүлэх; 16.1.5.нийгмийн ажлын үйлчилгээг үнэлэх; 16.1.6.нийгмийн ажлын үйлчилгээг хаах.	
16.2.Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат, хэрэгжүүлэх үйл ажиллагааг стандартаар тогтоох бөгөөд уг стандартыг Нийгмийн ажилтны холбоо, стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулна.	Холт Интернэшнл байгууллага 16.2-ийг холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг нягтлан үзнэ үү?
16.3.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд олон улсын байгууллагаас баталсан, нийтээр хүлээн зөвшөөрсөн нийгмийн ажлын үйлчилгээний стандарт, удирдамж, зөвлөмжийг хэрэглэж болно.	
16.4.Энэ зүйлд заасан гадаад улсын болон олон улсын стандартыг хэрэглэхээр бол Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны үндэсний стандартаар бүртгүүлнэ.	

17 дугаар зүйл.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний баримтжуулалт

17.1.Нийгмийн ажилтан нь шууд үйлчилгээний тэмдэглэлийг хууль, тогтоомжид заасан стандартад нийцүүлэн цаасан болон цахим хэлбэрээр хөтөлж, нийгмийн ажил, үйлчилгээний нийтлэг шаардлага стандартын дагуу хадгалах бөгөөд хуульд заасан тохиолдолд холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид танилцуулна.	"Хөөрхөн Зүрх" ТББ ...үйлчлүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр
--	--

17.2.Нийгмийн ажлын шууд үйлчилгээний хүрээнд баримтжуулсан мэдээллийг энэ хуульд заасан мэдээллийн санд байршуулж, үйл ажиллагаанд ашиглана.	
---	--

18 дугаар зүйл.Нийгмийн шууд бус үйлчилгээ

18.1.Нийгмийн шууд бус үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд: 18.1.1.олон улсын нийгмийн ажил; 18.1.2.нийгмийн ажлын бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үнэлэх; 18.1.3.нийгмийн ажлын судалгаа; 18.1.4.нийгмийн бодлогын нөлөөлөл;	
18.2.Нийгмийн ажилтны мэргэжлийн зэрэг, дэв тогтоох, мэргэшсэн нийгмийн ажилтныг тодорхойлоход энэ зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан үйлчилгээний туршлага, үзүүлэлтийг харгалзан үзнэ.	

ГУРАВДУГААР БҮЛЭГ

НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

19 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

19.1.Улсын их хурал нь нийгмийн ажлын үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 19.1.1.нийгмийн ажлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох; 19.1.2.нийгмийн ажлын үйлчилгээний талаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; 19.1.3.нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган батлах; 19.4. хуульд заасан бусад;	
--	--

20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

20.1.Засгийн газар нь нийгмийн ажлын үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 20.1.1.нийгмийн ажил үйлчилгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 20.2.1.нийгмийн ажлын үйлчилгээний бодлого, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх; 20.3.1.нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах; 20.4.1 хуульд заасан бусад	
--	--

21 дүгээр зүйл.Хоёр талт үндэсний хороо

21.1.Засгийн газар, Нийгмийн ажилтны холбооны төлөөлөл хоёр талт хороо байгуулж, хоёр жил тутам зөвшилцөж төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдал, цалин хөлс, зэрэг дэвтэй холбоотой асуудлаар тогтоол шийдвэр гаргана.	Цөлийн сарнай ТББ ТББ- д ажиллаж буй нийгмийн ажилтны урамшуулал, тэтгэвэрт гарахад 36 сартай дүйцэх тэтгэмжид төрийн албан хаагчтай адилхан тооцон олгодог байхаар тусгах. Холт Интернэшнл байгууллага 21 дүгээр зүйлийг дахин сайтар нягтлана уу. Ажлын орон тооны алба нь аль байгууллагын харьяанд байх вэ? Хэдэн орон тоотой, төсвийн орлого нь хэд байх талаарх тооцоо судалгаа байгаа юу?
21.2.Хоёр талт хороо тэдгээрийн гишүүд нь бие дааж, хараат бусаар ажиллана.	
21.3.Үндэсний хорооны дүрмийг Засгийн газар батална.	
21.4.Хоёр талт үндэсний хороо ажлын албатай байна. Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	
21.5. Үндэсний хороо дараах чиг үүрэг хэрэгжүүлнэ: 21.5.1.төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтны цалин хөлстэй холбоотой асуудлаар тогтоол гаргах; 21.5.2.нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах; 21.5.3.нийгмийн ажлын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах, хууль тогтоомжийн төсөлтэй урьдчилан	Цөлийн сарнай ТББ Бүх салбарт ажиллаж буй нийгмийн ажилтныг хамтатгах

танилцах, батлагдахаас өмнө саналаа хүргүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх; 21.5.4.энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд холбогдох журам, дүрэм, аргачлал батлан мөрдүүлэх, тогтоол батлах; 21.5.6.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.	
--	--

22 дугаар зүйл.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага

22.1.Нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг тухайн салбарын хуулиар эрх олгосон төрийн байгууллага, түүний ажилтан нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ.	“Хөөрхөн Зүрх” ТББ ...түүний ажилтан бус мэргэжлийн нийгмийн ажилтан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх
22.2.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага нь үйлчлүүлэгчид нийгмийн ажлын шууд үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтантай байх бөгөөд төрийн байгууллагад ажиллах нийгмийн ажилтны жишиг тоог хүн амын нягтрал, шилжилт хөдөлгөөн, эрсдэлт бүлгийн хүн ам, үйлчлүүлэгчийн тоо, салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно.	
22.3.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага бүр нийгмийн ажилтны ажлын байранд мэргэжлийн нийгмийн ажилтныг шалгаруулж авах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн ажилтныг нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагаар хангана.	
22.4.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага нь нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтэд нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх бодлого, чиглэл, санхүү, хүний нөөцийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангана.	
22.5.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага нь үзүүлж буй нийгмийн ажлын шууд үйлчилгээнийхээ талаар бүртгэл хийж, энэ хуульд заасан мэдээллийн санд бүртгүүлнэ.	

23 дугаар зүйл.Нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд

23.1.Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхээр дүрэмдээ заасан мэргэшсэн хуулийн этгээд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлнэ.	
23.2.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан нийгмийн ажлын шууд үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд бие даан үзүүлж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. 23.2.1.хоёроос доошгүй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтантай байх; 23.2.2.нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн хариуцлагын даатгалд байх; 23.2.3.үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх; 23.2.4.хүсэлт гаргагч хуулийн этгээд нь дотоод журамдаа нийгмийн ажлын үйлчилгээний үндэсний стандартад нийцсэн аргачлалыг тусгасан байх; 23.2.5.хүсэлт гаргагч хуулийн этгээд нь өөрийн дотоод журамдаа санхүүгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах;	“Хөөрхөн Зүрх” ТББ Ерөнхий санал: Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлах, шалгах зэрэг дахиад л ТББ-уудыг хянаж шалгах, эрх олгох зэрэг л заалтууд байгаагаас хэрхэн дэмжих, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх санхүүжилтийг хэрхэн гаргах зэрэг заалтууд байхгүй байна.
23.3.Нийгмийн ажил үйлчилгээг бие даан эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 24.2-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл дараах баримт бичгийг бүрдүүлэн Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанд хүргүүлнэ: 23.3.1.нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн гэрчилгээ 23.3.2 .хуулийн этгээдийн дүрэм, дотоод журам 23.3.3.Энэ хуулийн 24.3-т заасан шаардлагыг хангасан бусад баримт бичиг;	
23.4.Хорооны ажлын алба энэ хуулийн 24.4-т заасан хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянаж, шаардлага хангасан хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх саналыг Нийгмийн ажилтны холбооны Мэргэжлийн Хороонд хүргүүлнэ.	
23.5.Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанаас энэ хуулийн 24.5-д заасан саналыг үндэслэн Мэргэжлийн хороо нийгмийн ажлын үйлчилгээ явуулах хуулийн этгээдийг 3 жилийн хугацаагаар магадлан итгэмжилнэ.	Цөлийн сарнай ТББ 3 жилээ 5 жилээр магадлан итгэмжлэх
23.6.Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар 15 хоногийн дотор Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанд мэдэгдэж бүртгүүлнэ.	

--	--

24 дүгээр зүйл. Нийгмийн ажилтан нийгмийн ажлын шууд үйлчилгээ эрхлэх

24.1.Энэ хуульд заасан нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын шууд үйлчилгээг Нийгмийн ажилтны холбооны нэгдсэн бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр үзүүлэх ба нийгмийн ажлын мэргэжлийн дүрмийг баримтална.	
24.2.Нийгмийн ажилтны холбоо нь нийгмийн ажилтныг мэргэжлийн чиглэлээр бүртгэж, чадавхижуулна.	

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙГМИЙН АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО

25 дугаар зүйл.Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоо, түүний гишүүнчлэл

25.1.Нийгмийн ажилтны холбооны үйл ажиллагааг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлно.	
25.2.Нийгмийн ажилтны холбоо нийгмийн ажилтны мэргэжлийн нэр хүнд, үйл ажиллагаа, хариуцлагын нэгдсэн стандарт тогтоох, нийгмийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.	
25.3.Энэ хуульд заасан нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийгмийн ажилтан нь нийгмийн ажилтны холбооны гишүүнчлэлтэй байх бөгөөд нийгмийн ажилтан мэргэжилтэй этгээд нь гишүүн байж болно.	
25.4.Нийгмийн ажилтны холбооны эрх барих дээд байгууллага нь нийт гишүүдийн их хурал байна.	
25.5.Нийгмийн ажилтны анхдугаар их хурлаар Нийгмийн ажилтны холбоог байгуулах бөгөөд Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулна.	

25.6.Нийгмийн ажилтны холбоо нь Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ажлын алба, Мэргэжлийн хороо болон бусад төрлийн хороодтой байна.	
25.7.Нийгмийн ажилтнууд сайн дураараа нэгдэж байгуулсан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд нь нийгмийн ажилтны холбооны үйл ажиллагаанд эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар оролцож болно.	

26 дугаар зүйл.Нийгмийн ажилтны холбооны чиг үүрэг

26.1. Нийгмийн ажилтны холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 26.1.1.нийгмийн ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах; 26.1.2.нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм батлах, сахиулах; 26.1.3.мэргэжлийн хороо байгуулан ажиллуулах; 26.1.4.нийгмийн ажилтны үргэлжилсэн сургалтыг зохион тооцох; багц цагийг байгуулах, 26.1.5.нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох 26.1.6.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжлийн үзүүлэх шинжээчийн тусалцаа 26.1.7.нийгмийн ажлын шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, хийх; судалгаа шинжилгээ 26.1.8. мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, нийгмийн ажилтны нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа зохион байгуулах; 26.1.9.нийгмийн ажилтны нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журмыг батлах.	
--	--

27 дугаар зүйл.Нийгмийн ажилтны Их хурал

27.1. Нийгмийн ажилтны Их хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 27.1.1.Нийгмийн ажилтны холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт оруулах; өөрчлөлт 27.1.2.Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох; 27.1.3. Нийгмийн ажилтны Удирдах зөвлөлийн гишүүдийг	
---	--

батламжлах, 27.1.4. Мэргэжлийн хариуцлагын хороо байгуулж, бүрэлдэхүүнийг чөлөөлөх; батламжлах, 27.1.5. Нийгмийн ажилтны холбооны Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонгох, зөвлөмж өгөх; 27.1.6. Нийгмийн ажилтны холбооны гишүүний татварын хэмжээг тогтоох; 27.1.7. Нийгмийн ажилтны холбооны дүрмээр тогтоосон бусад чиг үүрэг	
27.2. Нийгмийн ажилтны Их хурлын ээлжит хуралдаан гурван жилд нэг удаа хуралдах бөгөөд Нийгмийн ажилтны их хурал хуралдааныг нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч даргална.	
27.3. Нийгмийн ажилтны Их хурлын төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.	
27.4. Нийгмийн ажилтны Их хуралд оролцох нийгмийн ажилтны төлөөлөгчдийг сонгох журмыг Нийгмийн ажилтны холбооны дүрмээр тогтооно.	
27.5. Нийгмийн ажилтны Их хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөөлөгөөг хуралдаан эхлэхээс 90 хоногийн өмнө Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.	
27.6. Нийгмийн ажилтны их хурал энэ хуулийн 28.1.1, 28.1.2, 28.1.6-д заасан асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн энгийн олонхын саналаар, бусад асуудлыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын саналаар тус тус шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана.	
27.7. Нийгмийн ажилтны их хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар Нийгмийн ажилтны их хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа бичгээр, эсхүл цахим хэлбэрээр битүүмжлэн ирүүлж болно.	
27.8. Энэ хуулийн 28.7-д заасны дагуу ирсэн саналыг хэлэлцэх журмыг хуралдааны дэгээр зохицуулна.	

28 дугаар зүйл. Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч

28.1.Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч нь нийгмийн ажилтны хувьд нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, манлайлагч байна.	
28.2.Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг улируулан сонгохгүй.	
28.3.Нийгмийн ажилтны холбооны Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28.3.1.нийгмийн ажилтны холбооны зөвлөлтэй зөвшилцөн Их хурлыг зарлан хуралдуулах; 28.3.2.нийгмийн ажилтны холбооны зөвлөлийн хуралдааныг даргалах; 28.3.3.холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх; 28.3.4.холбооны зөвлөлд Нийгмийн ажилтны холбооны ажлын албаны даргад нэр дэвшүүлэх; 28.3.5.энэ хуулиар болон Нийгмийн ажилтны холбооны дүрмээр олгосон бусад бүрэн эрх.	
28.4.Ерөнхийлөгч нь Нийгмийн ажилтны холбооны Ажлын албаны үйл ажиллагаанд оролцохгүй.	

29 дүгээр зүйл.Нийгмийн ажилтны холбооны Удирдах зөвлөл

29.1.Нийгмийн ажилтны холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах, бодлогыг тодорхойлох чиг үүрэгтэй хамтын удирдлагын байгууллага байна.	
29.2.Нийгмийн ажилтны холбооны Удирдах зөвлөл нь 15-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүд хороодын төлөөлөл байна.	
29.3.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно.	

29.4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно.	
29.5.Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.	
29.6.Энэ хуулийн 30.2-т заасан гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр удирдах зөвлөлийн хурал хүчинтэй болох бөгөөд хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар шийдвэр батлагдана.	

30 дугаар зүйл.Мэргэжлийн хорооны бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг

30.1.Нийгмийн ажилтны холбооны дэргэд орон тооны Мэргэжлийн хороо (цаашид Хороо) ажиллана.	
30.2.Мэргэжлийн хорооны гишүүдийг Нийгмийн ажилтны холбооны Их хурлаас сонгоно.	
30.3.Хороо нь есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүдийн олонхын саналаар хорооны даргыг дотроосоо сонгоно.	
30.4.Хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.	
30.5.Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь ээлжит болон ээлжит бус хуралдаан байна.	
30.6.Хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.	
30.7.Ээлжит бус хурлыг хорооны гишүүдийн саналыг үндэслэн хорооны даргын шийдвэрээр хуралдуулж болно.	
30.8.Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болно.	
30.9. Мэргэжлийн Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 30.9.1.нийгмийн ажилтны нэгдсэн бүртгэл хөтлөх; 30.9.2.хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, бүртгэх; 30.9.3.нийгмийн ажлын үйлчилгээний магадлан итгэмжлэлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, түүнд хамаарах журам батлах, хэрэгжүүлэх;	

30.9.4.нийгмийн ажилтнуудыг сургах, давтан сургах сургалт зохион байгуулах; 30.9.5.өөрийн эрх хэмжээний хүрээнд холбогдох стандартыг мөрдүүлэх;	
--	--

31 дүгээр зүйл.Мэргэжлийн хариуцлагын хорооны бүтэц, зохион байгуулалт

31.1.Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон нийгмийн ажилтны ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох,нийгмийн ажилтны ёс зүйн асуудлаар судалгаа хийх зэрэг ажлыг нийгмийн холбооны нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо /цаашид "Ёс зүйн хороо" гэх/ зохион байгуулна.	
31.2. Ёс зүйн хороонд нийгмийн ажилтны ёс зүйн асуудлаар судалгаа хийдэг, нийгмийн ажилтны мэргэжлийн сургуульд тухайн чиглэлээр хичээл заадаг профессор болон нийгмийн ажилтны ёс зүйн боловсролыг дээшлүүлэх, ёс зүйн хувьд нийгмийн ажилтныг манлайлах эрмэлзлэлтэй нийгмийн ажилтнууд сайн дураар нэгдэн ажиллана.	
31.3.Ёс зүйн хорооны гишүүн нь Мэргэжлийн хариуцлагын хорооны гишүүнээр нэр дэвшиж байгаа нийгмийн ажилтны зан байдлын талаар дүгнэлт гаргах шинжээчээр ажиллаж болно.	
31.4.Ёс зүйн хороо Нийгмийн ажилтны мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал болон нийгмийн ажилтан мэргэжлийн дүрмийн хэрэгжилтийн тайланг Зөвлөлд танилцуулна.	
31.5.Мэргэжлийн хариуцлагын хороо нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан мэргэжлийн хорооны журмын нэгэн адил ажиллана.	
31.6.Мэргэжлийн хариуцлагын Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 31.6.1.нийгмийн ажлын үйлчилгээний үйл ажиллагаанд гаргасан гомдлыг шийдвэрлэх; 31.6.2.нийгмийн ажилтны мэргэжлийн болон ёс зүйн дүрэм зөрчсөн талаар гаргасан гомдлыг шийдвэрлэх;	

31.6.3.нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	
--	--

32 дугаар зүйл. Хяналтын зөвлөл

32.1.Хяналтын зөвлөл нь Нийгмийн ажилтны холбооны эд хөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.	
32.2.Хяналтын зөвлөл нь Нийгмийн ажилтнаас бүрдсэн таван гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг гурван жилийн хугацаагаар томилно.	
32.3. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг холбооны дүрмээр батална.	

33 дугаар зүйл.Ажлын алба

33.1.Нийгмийн ажилтны холбооны Үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий Ажлын албатай байна.	
33.2.Нийгмийн ажилтны холбооны ажлын алба холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Мэргэжлийн хороог үйл ажиллагаа явуулах боломжоор хангана.	
33.3.Хорооны ажлын алба энэ хуулийн нийгмийн ажилтныг бүртгэж, аль нэг салбараар мэргэшсэн талаарх нийтэд нээлттэй зарлана.	
33.4.Нийгмийн ажилтны ёс зүйн талаар гаргасан гомдол болон хуулийн этгээд үйл ажиллагаанд гаргасан гомдлыг Хорооны ажлын албанд гаргах бөгөөд ажлын алба гомдлыг хүлээн авч бүртгэн, Мэргэжлийн хорооны аль нэг гишүүнд санамсаргүй байдлаар хуваарилна.	
33.5. Холбооны Ажлын алба нийгмийн ажилтнуудын нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.	
33.6. Хорооны гишүүн гомдлыг хүлээн авч, гомдолтой холбоотой нотлох баримтыг цуглуулж шалгаад гомдлыг хэлэлцэх үндэслэлгүй гэж үзвэл энэ талаар гомдол гаргагчид хариу мэдэгдэх бөгөөд гомдлыг хэлэлцэх	

үндэслэлтэй гэж үзвэл үргэлжлүүлэн шалгаж, хорооны нийт гишүүдэд танилцуулж шийдвэрлэнэ.	
33.7.Хорооны нийт гишүүд гомдлыг хэлэлцээд дараах тогтоол гаргана: 33.7.1.нийгмийн ажилтан, хуулийн этгээдэд сануулах; 33.7.2.нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийг түр хугацаагаар хязгаарлах; 33.7.3.хуулийн этгээдийг магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох;	

34 дүгээр зүйл.Нийгмийн ажилтныг бүртгэх, хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх

34.1.Энэ хуульд заасан шаардлага хангасан нийгмийн ажилтан бүртгүүлэх хүсэлтээ холбогдох баримтын хамт Мэргэжлийн Хороонд гаргана.	
34.2.Хороо энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д заасан хүсэлт, холбогдох баримтыг ажлын 10 хоногийн дотор шалгаж шаардлага хангасан тохиолдолд нийгмийн ажилтныг мэргэжлийн чиглэлээр ангилж, бүртгэнэ.	
34.3.Нийгмийн ажилтан нь энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх явцад мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан бол зөрчлийн шинж байдал, маргааны талуудад учруулсан хор уршиг, үр дагаврыг харгалзан мэргэжлийн дүрэмд заасан хариуцлагыг оногдуулна.	
34.5.Хороо нь дараах үндэслэлээр нийгмийн ажилтныг нэгдсэн бүртгэхээс татгалзана: 34.5.1.нийгмийн ажилтны эрхийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон; 34.5.2.нийгмийн ажилтны гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон; 34.5.3.нийгмийн ажилтны иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон; 34.5.4.нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан мэдээллийг задруулсан; 34.5.5.хуульд заасан бусад	
35.6.Хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх асуудлыг Мэргэжлийн хорооны дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.	

ТАВДУГААР БҮЛЭГ

НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, БАТАЛГАА

36 дугаар зүйл. Нийгмийн ажилтан

36.1.Нийгмийн ажилтан нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан нийгмийн ажлын шууд болон шууд бус үйлчилгээг үзүүлэх этгээдийг хэлнэ.	
36.2.Нийгмийн ажилтан хууль тогтоомжид заасан эрх, үүрэг, мөргөжлийн үйл ажиллагааны чиглэлээр чадавхиж, энэ хуульд заасны дагуу нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ.	

37 дугаар зүйл.Нийгмийн ажилтны нийтлэг эрх, үүрэг

37.1. Нийгмийн ажилтан дараах нийтлэг эрхийг эдэлнэ: 37.1.1.нийгмийн ажлын мөргөжлийн үйл ажиллагаа эрхлэх; 37.1.2.хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах нөхцөл, баталгааг бүрдүүлэх, түүнийг сайжруулахыг шаардах; 37.1.3.нийгмийн ажилтны эрх, хууль ёсны сонирхлоо хамгаалуулахаар эвлэлдэн нэгдэх; 37.1.4.төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг биелүүлэхээс татгалзах; 37.1.6.хуульд заасан бусад эрх;	
37.2. Нийгмийн ажилтан нь дараах үүргийг хүлээнэ. 37.2.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт болон Нийгмийн ажилтны мөргөжлийн дүрмийг мөрдөх; 37.2.2.үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх; 37.2.3.үйлчлүүлэгчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг нотолгоонд тулгуурлан тодорхойлох, үр нөлөөг судлах; 37.2.5.нийгмийн ажилтны үйл ажиллагаа, шийдвэр хуульд нийцсэн байх;	

37.2.6.мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан мэдээлэл болон үйлчлүүлэгчийн нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх; 37.2.7.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу нийгмийн ажлын үйлчилгээг хараат бусаар үзүүлэх; 37.2.8.өөрийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлэх, мэргэжлийн чиглэлээр багц цагийн сургалтад хамрагдах; 37.2.9.мэргэжлийн үйл ажиллагаагаа ажил олгогчийн өмнө, мэргэжлийн ёс зүйн хариуцлагаа Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоонд хариуцан тайлагнах; 37.2.10.хуульд заасан тохиолдолд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах; 37.2.11.хууль тогтоомжид заасан тохиолдолд Нийгмийн ажилтны холбооны гишүүнчлэлийн хураамж төлөх; 37.2.12. хуульд заасан бусад үүрэг.	
---	--

38 дугаар зүйл.Нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм

38.1.нийгмийн ажилтан нь энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм /цаашид "Нийгмийн ажлын мэргэжлийн дүрэм" гэх-тэй байна.	
38.2.нийгмийн ажлын мэргэжлийн дүрмийг Нийгмийн ажилтны холбооны Их хурлаар батална.	

39 дүгээр зүйл.Нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох зүйл.

39.1.нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хориглоно: 39.1.1.улс төрийн үйл ажиллагаа явуулах, улс төрийн намын гишүүнчлэлтэй байх; 39.1.2.хуульд зааснаас бусад тохиолдолд үйлчлүүлэгчийн хувийн нууцыг задруулах 39.1.3.нийгмийн ажилтны нэрийг өөр зорилгоор ашиглах; 39.1.4.хувийн давуу байдлаа ашиглах, харилцаа тогтоох, эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах, авлига авах,	
---	--

ялгаварлан гадуурхаж харилцах зэрэг ашиг сонирхлын зөрчил гаргах; 39.1.6.Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, хууль ёсны зарчмын эсрэг үйл ажиллагаа явуулах; 39.1.7.үйлчлүүлэгчийнхээ болон нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд нь өртөж байгаа этгээдийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн болон бусад этгээдийн нэрээр худалдан авах, эсхүл өөр бусад аргаар олж авах, эзэмших, гэмтээж сүйтгэх;	
---	--

40 дүгээр зүйл.Мэргэжлийн удирдлага, үргэлжилсэн сургалт

40.1.нийгмийн ажилтан нь мэргэжлийн удирдлагаар хангагдаж, үргэлжилсэн сургалтад хамрагдана.	
40.2.Мэргэжлийн удирдлагаар хангах, үргэлжилсэн сургалт зохион байгуулах журмыг Нийгмийн ажилтны холбооны Мэргэжлийн хороо баталж, хэрэгжүүлнэ.	

41 дүгээр зүйл.Мэргэшсэн нийгмийн ажилтан

41.1.Хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу болон нийгмийн ажлын салбар, тодорхой чиглэлээр нийгмийн ажилтан мэргэшин ажиллана.	
--	--

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
МЭДЭЭЛЛИЙН САН**

42 дугаар зүйл. Мэдээллийн сан

42.1.Нийгмийн ажлын үйлчилгээний мэдээлэл гэж дор дурдсан агуулга бүхий бичгэн, дуу авиа, дүрс бичлэг, цахим болон бусад хэлбэрийн өгөгдлийг хэлнэ. 42.1.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан нийгмийн ажлын шууд үйлчилгээний талаарх мэдээлэл: 42.1.2.Нийгмийн ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааны талаарх нэгдсэн мэдээлэл;	
--	--

42.1.3.Нийгмийн ажлын шууд бус үйлчилгээний талаар мэдээлэл, үр дүн, тайлан	
42.2.Мэдээллийн сан нь цаасан болон цахим хэлбэртэй байх бөгөөд нэгдсэн удирдлага зохицуулалт бүхий програм хангамжтай байна.	
42.3.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалтыг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийгмийн ажлын мэргэжлийн холбоо хамтран батална.	

43 дугаар зүйл.Мэдээллийн сан бүрдүүлэх ерөнхий шаардлага

43.1.Энэ хуулийн үйлчлэлд хамаарах эрх бүхий байгууллага, нийгмийн ажилтан нь мэдээллийн санд нотлох баримт бичигт үндэслэсэн үнэн зөв мэдээллийг оруулна.	
43.2.Мэдээллийн сан нь энэ хуульд заасан болон нийгмийн ажлын үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн болон хуулийн этгээдийн, нийгмийн ажилтны мэдээллээс бүрдэх бөгөөд төрийн байгууллагад ашиглагдаж байгаа систем, программ хангамжтай уялдсан байна.	
43.3.Мэдээллийн санд мэдээлэл бүртгэх, баяжуулах, баталгаажуулах чиг үүргийг хариуцсан албан хаагч мэдээллийн үнэн, бодит байдлыг хариуцаж ажиллана.	
43.4.Мэдээллийн сан нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан мэдээлэл хариуцагчтай байна.	
43.5.Мэдээллийн сан, түүний боловсруулалтын үр дүн, холбогдох мэдээ тайлан нь мэдээлэл хариуцагчийн албан ёсны мэдээ, мэдээлэл, баримт бичиг байна.	
43.6.Мэдээллийн санд нийгмийн ажлын үйлчилгээний мэдээллийг төвлөрүүлэн байршуулах бөгөөд мэдээллийг баталгаажуулахдаа дэвшилтэд технологийг ашиглаж болно.	
43.7.Энэ хуульд заасан мэдээлэл хариуцагч нь мэдээллийн санг салбарын бодлого, төлөвлөлт, батлагдсан маягт, үзүүлэлт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд шинэчлэн бүрдүүлнэ.	

43.8.Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нэгдсэн ангилал, код, тайлбарыг давхардуулахгүй мөрдөнө.	
43.9.Мэдээллийн сан нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ашиглаж болно.	

44 дүгээр зүйл.Мэдээллийн санг ашиглах, хадгалах, хамгаалах

44.1.Мэдээллийн сангийн өгөгдөл нь нээлттэй, хаалттай гэсэн төрөлтэй байх ба иргэн, хуулийн этгээдэд хууль тогтоомжоор тусгайлан хамгаалснаас бусад мэдээллийг нээлттэй ашиглуулна.	
44.2.Энэ хуулийн зорилгод нийцүүлэн хуулиар нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхээр заасан төрийн байгууллага, Холбоо нь мэдээллийн сангийн хаалттай мэдээллийг нэгтгэн боловсруулж үйл ажиллагаанд ашиглана.	
44.3.Энэ хуульд заасан мэдээлэл солилцохдоо эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь мэдээлэл солилцох тухай албан хүсэлтийг сервис үйлчилгээний нэр, зориулалт, холбоо барих мэдээллийн хамт Нийгмийн ажлын үйлчилгээний төвд ирүүлнэ.	

45 дугаар зүйл.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага

45.1.Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоо мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.	
45.2.Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбооны дэргэд улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах нийгмийн ажлын үйлчилгээний мэдээллийн төв ажиллана.	
45.3.Нийгмийн ажлын үйлчилгээний мэдээллийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 45.3.1.Мэдээллийн сангийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах; 45.3.2.Мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, хамгаалах, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;	

45.3.3.Мэдээллийн сангийн хүрээнд программ хангамж, техник технологи, хүний нөөцийн нэгдмэл бодлого хэрэгжүүлэх, тэдгээрийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх;

45.3.4.Хэрэглэгчийг мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;

45.3.5.Нийтийн хэрэгцээний болон хоёрдогч мэдээллийг бий болгоход шаардлагатай мэдээлэл боловсруулах;

45.3.6.Мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд бүртгэл хөтлөх, баримтжуулах;

45.3.7.Мэдээллийн сангийн мэдээллийг энэ хуульд зааснаас бусад иргэн, хуулийн этгээдээс цуглуулах, сонгох, нягтлан шалгах ажлыг зохион байгуулах;

45.3.8.Мэдээллийн бүрэн, мэдээллийн сангийн шуурхай байдал, хэвийн ажиллагаа, хамгаалалт, хадгалалт, нууцлалт, хуулбарлалтыг хариуцах;

45.3.9.Мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх;

45.3.10.Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;

45.3.11.Мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар мэдээлэл бүрдүүлэх, төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

45.3.12.Мэдээллийн санд өөрчлөлт хийх, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сангийн талаарх тайланг жил бүр гаргах;

45.3.13.Мэдээллийн санд халдлага, гэмтэл гарсан даруйд холбогдох байгууллагад мэдэгдэх, түүний хэвийн үйл ажиллагааг сэргээх;

45.3.14.Мэдээллийн сангийн асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

45.3.15.Мэдээллийн санг зориулалтын байр, программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай өгөгдөл, мэдээлэл худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах.

	45.4. Нийгмийн ажлын үйлчилгээний мэдээллийн төв мэдээллийн сангийн үр ашиг болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2 жил тутам хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлнэ.
46 дугаар зүйл. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл	
	46.1.Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно: 46.1.1.Мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг өөрчлөх, устгах, хулгайлах; 46.1.2.Мэдээллийн сангийн программ хангамжийг өөрчлөх, устгах, эвдэх; 46.1.3.Мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай үйл ажиллагааг санаатай болон санамсаргүйгээр алдагдуулах, эвдэх, гэмтээх; 46.1.4.Мэдээллийн санд вирус тараах; 46.1.6.Мэдээллийн санд агуулагдаж буй иргэн, хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах; 46.1.7.Мэдээллийн сангаас авсан мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, худалдах; 46.1.8.Мэдээллийн сангаас санаатай болон болгоомжгүйгээр мэдээлэл хуулбарлах, ишлэлгүйгээр ашиглах; 46.1.9.Ашиглах хүрээг нь хязгаарласан өгөгдөл, мэдээлэлд хууль бусаар нэвтрэх, тэдгээрийг өөрчлөх, хуулбарлах, устгах; 46.1.10.Мэдээллийн санд хандах эрхийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах; 46.1.11.Мэдээллийн сангийн ажилтан хуулиар хүлээсэн давуу эрхтэй холбоотойгоор өгөгдөл, мэдээлэл болон мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулах.
47 дугаар зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт	
	47.1.Мэдээллийн санг бүрдүүлэхэд улсын төсвөөс нэг удаа санхүүжүүлэх бөгөөд цаашид Нийгмийн ажилтны холбоо хариуцна.
	47.2.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд

бүрдүүлсэн мэдээллийг энэ хуульд заасан мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.	
---	--

ДОЛООДУГААР БҮЛЭГ.

БУСАД ЗҮЙЛ

48 дугаар зүйл. Нийгмийн ажлын тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

48.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчил, гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	“ГҮНЖ” төв ТББ Албан тушаалтан гэж хэнийг хэлж байгаа вэ? Нийгмийн ажилтан уу? ОУ-ын байгууллага, ТББ-д ажилладаг нийгмийн ажилтан хууль зөрчсөн үйлдэл гаргавал яах вэ? Ямар хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэх вэ? Энэ заалт нь зөвхөн төрийн байгууллагад ажилладаг нийгмийн ажилтнуудад зориулагдсан санагдаж байна.
48.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	“ГҮНЖ” төв ТББ зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол... гэж нэмж, тодорхой болгож оруулах хэрэгтэй байх.

49 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

49.1.Энэ хуулийг 2027 оны ... дүгээр сарынний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
--	--

ГАРЫН ҮСЭГ



Огноо: 2025.09.11
mbujgar@gmail.com

№ 25

Улаанбаатар хот
Утас: 99168685

УИХ-ын гишүүн О.Саранчулуун танаа

Санал хүргүүлэх тухай

УИХ-ын гишүүн О.Саранчулуун, А.Ариунзаяа, Х.Булганзаяа нарын санаачлан боловсруулсан Нийгмийн ажлын тухай хуулийн талаарх 6 удаагийн хэлэлцүүлэгийн 3 удаагийн хэлэлцүүлэгт СНАН оролцож санал хүсэлтээ илэрхийлэн хамтран ажилласан байна.

2025.09.09 өдрийн хуулийн хэлэлцүүлэгт оролцож дараах саналыг хүргүүлж байна.

1. хуулийн 2.1 заалт дээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Олон Улсын Нийгмийн Ажилтнуудын Холбоо гэж оруулах
2. 4.1.3 заалт иргэн гэдгийг хасах
3. 7.1 Нийгмийн ажлын шууд үйлчилгээний үндэс нь урьдчилан сэргийлэх үйлчилгээ байдаг учраас 7.1.1 Урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэж эхлэх
4. 16.2 найруулга, нэр томъёог зөв бичих, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих
5. 16.3 Олон улсын байгууллага- Олон Улсын Нийгмийн Ажилтнуудын Холбоо болон нийгмийн ажлын мэргэжил өндөр хөгжсөн орны нийтээр хүлээн
6. 4-р бүлэг Монголын Нийгмийн Ажилтны Мэргэжлийн Нэгдсэн Холбооны бүтцийг Ц. Нацагдолгор багшийн гаргасан санал дээр үндэслэх саналтай байна. Мэргэшлийн зэрэг, Лицензийн хороо, лиценз гэдэг нийгмийн ажилтанд үйлчилгээ үзүүлэх эрх олгох үйл явц, олон жил тууштай ажилласан салбарын мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран гүйцэтгэх гэж, мэргэшлийн зэрэг гэдэг нийгмийн ажилтан ажиллуулж байгаа яамны шийдэх асуудал, гэхдээ хуулинд нийгмийн ажилтан мэргэшлийн зэрэгтэй байна гээд оруулах
7. 30.9.5 өөрийн эрх хэмжээний хүрээ гэж юуг хэлж байна вэ, нэгэнт батлаад гаргасан салбарын хууль, дүрэм журмыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлэх ажлыг мөрдүүлэх
8. 37-р зүйл нийгмийн ажилтны эрх 37.1.1 нэмэх
 - Нийгмийн ажилтан хүний эрхийг хамгаалагч, иймээс Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хуультай нийцүүлэх
 - Хүний болон хүүхдийн эрхийн зөрчил болон холбогдох асуудлаар ямар ч албан тушаалтанд гомдол, санал, нэхэмжлэл гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй

- Салбарын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан төрийн үйлчилгээний албан тушаалтанд хамаарах эрхийг эдлэх (орон сууц, эрүүл мэнд, халамж г.м\
- Хүний эрхийн болон хүүхдийн эрхийн асуудлаар эрсдэлт нөхцөлд ажиллахад цагдаагийн байгууллагын дэмжлэг туслалцаа авах эрхтэй
- 37.2 нийгмийн ажилтны үүрэгт хамтын хариуцлага хүлээнэ гэж оруулах

9. 39-р зүйл хориглох Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хуулийг хараарай

10. 44-р зүйл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай холбох мэдээллийн сан хамгийн чухал, мэдээллийг архивын материал болгон хадгалах гэдэгт анхаарч оруулах

Маш их ажиллаж байгаад талархал илэрхийлье. Хууль батлагдах цаг хугацаа хүртэл хамтран ажиллах болно. Амжилт ерөөе

Хүндэтгэсэн



Тэргүүн

[Handwritten signature]

Б.Мөнхжаргал МУГБ

НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬӨГ

2025.09.25

Д/д	Хэлэлцүүлэгт оролцогч	Санал	Хуулийн төсөлд тусгасан байдал
1.	2024 оны 12 сарын 09 “Хүүхэд хамгааллын нийгмийн ажил” сэдвийн хүрээнд МУИС-ийн Багш оюутны хөгжлийн төвд зохион байгуулагдсан. МУИС Соц НА тэнхимийн багш нар оролцсон.	Хэтэрхий хуульчлаад баригдмал болгочих вий. Антропологи, социологи, эрүүл мэнд, уур амьсгал, газарзүй орон зайн баримжааны асуудлууд манай дээр ороод ирдэг. Нээлттэй баригдмал биш харах хэрэгтэй болов уу?. Энтерпрайз, бизнесийн асуудлууд орж ирдэг. Тогтвортой хөгжил, концептийн хувьд санал өгч байна. Хуулийн хувьд	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл Хуулийн зорилт дээр зохицуулах хүрээг тодорхой заасан.
2.	2024 оны 12 сарын 09 НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД МЭНДИЙН САЛБАРТ БУЙ АЖИЛТНУУДЫН БИЧГЭЭР ӨГГСӨН САНАЛУУД (и-мэйл болон цахимаар)	Нийгмийн ажлын тухай; хуулийн нэгдүгээр бүлэг: 1. Нийгмийн ажилтан гэж хэн бэ гэдгийг хуулийн нэр томъёоны тодорхойлолт дээр нэмэх 2. Нийгмийн ажилтныг төрөлжүүлж өгөх, салбаруудыг онцолж, онцлогийг тусгах / ЭМНА, Боловсролын НА, Хүүхэд хамгааллын НА, Хорих, Хороо халамж, Хөгжлийн гэх мэт мэргэжлийн нарийн тодорхойлолтыг оруулбал илүү ойлгомжтой. Эдгээрийг хуулийн нэр томъёоны хэсэгт нэмэх 3. Найруулгыг засах - Монгол улс нэгдэн орсон ОУ-ын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. 4. 2.1 - Эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан дээр Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, НЭМТҮ тухай хууль нэмэх Нийгмийн ажлын тухай хуулийн хоёрдугаар бүлэг: Нийгмийн ажлын тогтолцоонд нэмэх саналаа зүйл заалтыг дурдан доор бичнэ үү. 4. Нийгмийн ажлын тусламж, үйлчилгээний төрөл чиглэл, үйл ажиллагааны хүрээг тодорхой заах Ж нь: Сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтан нь ийм үйл ажиллагааг явуулна гэх мэт	1.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.“нийгмийн ажилтан” гэж Нийгмийн ажлын үйлчилгээг хүргэхэд шаардлагатай шинжлэх ухааны мэдлэг, ур чадвар, хандлагатай бүхий дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтнийг; гэж өөрчлөн найруулсан. 2.Дагалдах нийт 7 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бүхий нийгмийн ажилтны эрх зүйн байдлыг тодорхой зохицуулсан. 3.Найруулгыг зассан, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжтой уялдуулсан. 4.Нийгмийн ажил үйлчилгээний төрөл хэлбэрийг тус хуулийн төслийн 2 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тусгаж шууд болон шууд бус үйлчилгээтэй байхаар заасан. 5.Нийгмийн ажилтныг сургах, чадавхижуулах чиг үүргийг тус хуулийн 4 дүгээр бүлэгт заасан Нийгмийн ажилтны мэргэжлийн холбоо хариуцахаар заасан.

	5. 8.4т Олон жил ажилласан чадавхжуулах богино хугацааны сургалтад хамруулан мэргэжлийн үнэмлэх олгож, цаашид ажиллах нөхцөлөөр хангах, нийгмийн халамжид хамруулах 6. Өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх боломжийг хуульд заах, 7. НБҮ хийхэд хамтарсан багаар ажиллах хэлэлцэх 8. 8.3 Засгийн газар бус асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно гэж өөрчлөх Гуравдугаар бүлэг: Нийгмийн ажилтан, түүний эрх, үүрэгт нэмэх санал 1. Урамшуулал 20% олгох гэсэн заалт байна. Ингэж тоо тавьж хязгаарлаж хэрэггүй шиг. Аль нэг байгууллага ажилтандаа 40-60% хүртэл урамшуулал олгож болно. Тэр үед энэ саад болно. 2. Олон жил ажилласан ажилтнуудыг тэтгэмжид хамруулах заалт тусгах 3. 17.1-Найруулгыг засах-хөтөлбөр дүүргэн бакалаврын боловсрол эзэмшсэн..... гэж засах, 23.3 23.5 - хасах журмаар зохицуулах боломжтой, 24.1.11 24.1.12-нэгтгэх - найруулгыг засан нэгтгэх боломжтой утга ойр байна. 4. 22р зүйл ажлын байрны нийтлэг тодорхойлолт дээр шатлал бүрт хэрхэн ажиллах ямар ТҮ үзүүлэх вэ? гэдгийг тодорхой заалтуудыг оруулах. ЭМНА-н албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, тэдэн хүн амд 1 эмч байдаг гэдэг шиг тэдэн хүн амд 1 ЭМНА байна гэдгийг тодорхой болгох – 4 санал 7. 23.3.2-т Нийгмийн ажилтны мэргэшүүлэх сургалтыг эрүүл мэндийн салбарт идэвхтэйгээр зохион байгуулах, 8. 24.1.5-д Нийгмийн ажлын үндэсний зөвлөлд эрүүл мэндийн салбараас төлөөлөл оруулах, 11. Хуулийн уялдааг хангах, Ажлын тогтолцоог бэхжүүлэх 12. Ажлаас халшрах байдалд үнэлгээ, дүгнэлт өгдөг байх 13. Ахлах, тэргүүлэх, нийгмийн ажилтны хөдөлмөрийн үнэлэмж ямар байх, салбар дундаа хэрхэн шилжих, орлон ажиллах боломжтой байх, ЭМНА төгссөн ажилтан НЭМ чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, салбар дотроо хөрвөн ажиллах, боломжтой болгох. 15. Хүүхэд хамгааллын тухай хуульд хамтарсан багт эмч орно гэж заасан, үүнийг ЭМНА гэж нэмж болох уу? ЭМНА нар тогтмол хамтарсан багт	6. Энэ хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрүүл мэндийн нийгмийн ажилтан байхаар тусгасан. 7. НБҮ нь энэ хуулийн төслөөр зохицуулах харилцаа биш тул тусгаагүй. 8. Саналыг тусгав. Гуравдугаар бүлэг: Нийгмийн ажилтан, түүний эрх, үүрэгт нэмэх саналыг бүхэлд нь тусгаж, тухайн бүлгийг шинээр боловсруулсан Бүлгийн нэргийг Нийгмийн ажлын үйлчилгээнд оролцогч талууд хэмээн өөрчилж, Засгийн газар, Улсын Их Хурлын эрх үүргийг тодорхой болгосон. Нийгмийн ажлын үндэсний зөвлөлийн талаар зохицуулалтыг хассан. Мөн хуулийн төсөлд бусад салбарын нийгмийн ажил үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг давхар тусгах боломжгүй учир зарим зохицуулалтыг өөрчилж, ажлын байрны болон албан тушаалын тодорхойлолтой холбоотой саналуудыг тусгаагүй. Учир нь нийгмийн ажилтын 80 орчим хувь буюу 6000 нийгмийн ажилтан төрл ажиллаж байгаа ба төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар нийгмийн баталгаа, хууль зүйн баталгаа хангагддаг. Хуулийн төслөөс нийгмийн ажилтын мэргэжлийн үйл ажиллагаа тусгай зөвшөөрлийг хассан бөгөөд энэ нь төрийн албан хаагчийн эрх зүйн байдалд шууд нөлөөлөх цаашид карьерийн тогтолцоонд ач холбогдол багатай гэж
--	--	---

	орж байгаа тул, хийхгүй ёсгүй ажлаа хийж байгаа мэт байна. Хамтарсан багийг төсөвтэй байлгах- 2 санал Дөрөвдүгээр бүлэг: Нийгмийн ажлын үндэсний зөвлөл бүлэгт нэмэх саналаа зүйл 1. 24-р зүйл Нийгмийн ажлын баталгаанд хориглох зүйл холигдож орсон үүнийг халах /24.1.4, 24.1.11, 24.1.12/ 2. 29-р зүйл Нийгмийн ажилтны ерөнхий нийтлэг талаарх мэдлэг дээр салбар бүрийн онцлогийг нэмэх 3. Үндэсний зөвлөлийн орон тооны хувьд $3Г+ТББ=$ Мэргэжлийн зөвлөл, 25-р зүйлд үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд салбар бүрийн төлөөллийг тусгах 8. Нийгмийн ажилтныг мэргэжлүүлэх чиглэлийн сургалтын асуудлыг аль байгууллага хэрхэн хариулах вэ? гэдэг асуудлыг тусгах, нийгмийн ажлын үндэсний зөвлөл үү? тодорхой оруулах Тавдугаар бүлэг: Нийгмийн ажилтны мэргэжлийн шалгалт бүлэгт нэмэх саналаа зүйл 1. Шалгалтыг ажиллаж байх, сурч байх хугацаандаа хамрагдсан багц сургалттай дүйцүүлэх, (багц цаг хүрэхгүй бол заавал шалгалт өгөх зэрэг) 2. 30-35р зүйл хасах - журмаар зохицуулах боломжтой 3. Бакалавр төгсөөд дахин шалгалт өгнө гэдэг ойлгомжгүй 7. Төрийн албаны шалгалт, мэргэжлийн шалгалт 2 хамт биш мэргэжлийн шалгалт нь төрийн албаны шалгалттай дүйцэхүйц байх нь чухал Зургаадугаар бүлэг: Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоо бүлэгт нэмэх саналаа зүйл заалт 1. Нийгмийн ажилтан бүр НА-ын мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн байх шаардлагатай эсэхийг анхаарах 2. 37.1 Ёс зүйн асуудлыг орхигдуулсан байна, 37.2 бусад заалттай зөрчилтэй байна Нийгмийн ажлын ёс зүйн хорооны бүрэлдэхүүн тодорхой бус байна, Ёс зүйн салбар хороо ямар ямар хороодтой байх вэ 3. 40-р зүйл дээр нийгмийн хамгааллын салбар гэхээс илүү эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгаалал гэж салбар бүрийн мэргэжилтнүүдийн сонгогдох боломжоор хангах Долоодугаар бүлэг: Бусад хэсэгт нэмэх саналаа зүйл заалт 1. ЭМ-ийн салбарын ЭМНА мэргэшүүлэх сургалтад хамрагдах боломж	зарим оролцогчид үгнэсэн тул хассан ба энэ нь нь мэргэжлийн шалгалттай мөн холбогдож байсан тул төслөөс хассан. Өөрөөр хэлбэл нийгмийн ажилтны нэгдсэн бүртгэл, сургалтын үйл ажиллагаар чадавхижуулахаар хуулийн төсөлд тусгаж, лиценз, мэргэжлийн шалгалт, мэргэжлийн зэрэг дэв тогтоохтой холбоотой зохицуулалтыг хассан. Энэ нь мөн Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөлд хамаарахаар, Зөвшөөрлийн тоог нэмэхгүй байх талаар Засгийн газрын санал дүгнэлттэй давхаж байсан тул тухайн зохицуулалтуудыг төслөөс хассан. Үндэсний зөвлөлтэй холбоотой зохицуулалтыг хасч түүний оронд хуулийн төслийн 21 дүгээр зүйлд Хоёр талт үндэсний хороо гэж нэмж, тус зүйлийн 21.1-т “Засгийн газар, Нийгмийн ажилтны холбооны төлөөлөл хоёр талт хороо байгуулж, хоёр жил тутам зөвшилцөж төрийн байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтны эрх зүйн байдал, цалин хөлс, зэрэг дэвтэй холбоотой асуудлаар тогтоол шийдвэр гаргана.” гэж өөрчилсөн.
--	---	--

		хотор байна. 2. Ерөнхий хуулийн гол санаа маш НА дотор нь Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, боловсрол НА г.м тус тусад нь ялгаж заамаар байна.	1.Хуулийн төслийн үзэл баримтлалыг маш сайн боловсруулах; 2.Боловсролын салбарт ажиллаж буй нийгмийн ажилтнуудын нэгэнт олж авсан нийгмийн баталгааг дордуулах заалтууд тус хуулийн төсөлд туссан байгааг анхаарах; 3.Нийгмийн ажилтнуудын мэргэжлийн зэрэгтэй холбоотой зохицуулалтыг салбарынх нь ЗГ-ын гишүүн мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг баталгаажуулдаг байх гэдгээр хуульд тусгах 4.Нийгмийн ажилтнуудын мэргэжлийн нэгдсэн холбоо нь улс төрийн зорилготой, улс төрөөс хараат байгууллага болох эрсдэлийг анхаарч зохицуулсан заалт тусгах 5.Нийгмийн ажилтныг мэргэжлийн мэргэшсэн нийгмийн ажилтан мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах тухай зохицуулалтыг хуульд тусгах; 6.Хуулийн төслийн төслийн 8.2 заалтад мэргэшсэн төрийн байгууллага нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлнэ гэснийг “мэргэжлийн хүн үзүүлнэ” гэж өөрчлөх; 7.Хуулийн төслийн 8.6 заалтад мэргэжлийн программ гэдэг үгийг нэмж оруулах; 8.Хуулийн төслийн 4 дээр асран хамгаалагч гэдэг үг нэмж оруулах (хүүхдийн мэдээлэл задрах эрсдэлтэй байж болзошгүй); 9.6 дугаар хуудас 18.1.6 дээр хууль ёсны эрхээ хамгаалах гэж өөрчлөх; 10.Хуулийн төслийн 19.1.2 дээр үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлнэ гэсэн үгийг хэрэгцээ хязгааргүй учраас “үйлчлүүлэгчийн хэрэгцээний үнэлгээ дээр” тулгуурлан гэж өөрчлөн бичих; 11.Хуулийн төслийн 19.1.3 дээр үйлчлүүлэгчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг нотолгоо баримтад тулгуурлан гэж өөрчлөх; 12.Нийгмийн ажлын бакалаврын зэрэг эзэмшсэн хүнээс дахин шалгалт авах зохицуулалтыг өөрчлөх; 13.Мэргэжлийн удирдлага дээр 10 хүртэлх нийгмийн ажилтанд нэг ахлах, 5 хүртэлх нийгмийн ажилтанд нэг зөвлөх байна гэж хүүхэд хамгааллын хууль дээр заасан байна. Энэ нь тус хуультай зөрчилдөж байгааг анхаарах;
Хуулийн төслийн заалтыг өөрчлөн сайжруулахтай холбоотой санал 2024 оны 12 сарын 10 МУБИС, Нийгмийн ажлын арга зүйн тэнхим, Боловсролын нийгмийн ажилтнууд Сургуулийн нийгмийн ажлын нийгэмлэг МУБИС-ийн Нийгмийн ажилтан мэргэжлийн төгсөгчдийн холбоо Боловсрол Судлалын сургуулийн захирал Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн эрхлэгч НААЗТ-ийн багш нар, 52-р сургуулийн захирал, 38-р сургуулийн сургалтын менежер, БГД БХ мэргэжилтэн, Сэлэнгэ МСҮТ нийгмийн ажилтан, Техник технологийн политехник коллеж нийгмийн ажилтан Шинэ эрин сургууль, 57-р сургууль, 97-р сургууль, 40-р сургууль, 38-р сургууль, Сингапур сургууль, НД Голомт цогцолбор сургууль, 31-р сургууль, 79-р сургууль,	3.	1.Хуулийн үзэл баримтлалыг ахин шинээр боловсруулж батлуулсан. 2.Нийгмийн ажилтны баталгаатай холбоотой зохицуулалтыг шинээр нэмсэн. 3.Хуулийн төсөлд нийгмийн ажилтны цалин нийгмийн баталгааг хангах талаар 2 талт үндэсний хороо байгуулахаар тусгасан. 4.Мэргэжлийн холбоотой зохицуулалтыг тусгайлсан бүлэг болон Дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулсан. 5.Мэргэжлийн удирдлагатай холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 40 дүгээр зүйл. Мэргэжлийн удирдлага, үргэлжилсэн сургалт гэж шинээр тусган тус зүйлийн сургалтад хамрагдана. 40.1.нийгмийн ажилтан нь мэргэжлийн удирдлагаар хангагдаж, үргэлжилсэн сургалтад хамрагдана. 40.2.Мэргэжлийн удирдлагаар хангах, үргэлжилсэн сургалт зохион байгуулах журмыг Нийгмийн ажилтны холбооны Мэргэжлийн хороо баталж, хэрэгжүүлнэ. гэж тус тус тусгасан. Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт мэргэжлийн нэгдсэн холбооны талаар болон дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд тухайн холбоог байгуулах талаар завсрын хугацааны зохицуулалтыг тусгайлан боловсруулсан. Мөнхүү хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн	

23-р сургууль, 45-р сургууль, 112-р сургууль 33-р сургуулийн нийгмийн ажилтан, СБД НТБ төвийн нийгмийн ажилтан, МУИС-ийн харьяа ЕБС-ийн нийгмийн ажилтан, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн нийгмийн ажилтан	14.Хуулийн төслийн 6-р бүлэг дээр нэгдсэн холбоо гэж орж ирсэн байна. Энэ бүх салбарын нэгдсэн удирдлагаар хангах төлөөлөл бий болгох учраас хэн нэгэн ганц хүний удирдлагатай болохоос зайлсхийх зохицуулалтыг тусгах; 15.Хуулийн төслийн 34.1 -т нийгмийн ажилтан нэгдсэн холбоонд нэгдэнэ гэж заасан байна. Мөн 34.2 дээр нийгмийн ажилтан бүр гишүүн байна гэж заасан байна. Энэ нь сайн дурын байх ёсгүй юм уу. Мэргэжлийн нэгдсэн холбоо улс төрийн зорилготой, улс төрөөс хараат холбоо болох вий. Тиймээс энэ зохицуулалтыг сайжруулж тусгах; 16.Хүний нөөц нийгмийн ажлын салбарт дутагдалтай байна. Тиймээс хүний нөөцийг бэлтгэсэн хороо байгуулах тухай тусгах; 17.Сургуульд нийтээр нэг нийгмийн ажилтан байна гэж заасан байна. Үүнийг өөрчлөх; 18.Нийгмийн ажилтан гэсэн тодорхойлолтод нийгмийн ажилтан бэлтгэдэг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөртэй их дээд сургуулиудын дээд боловсрол эзэмшсэн гэж оруулах; 19.Нийгмийн ажилтнуудын ажлын нэмэгдлийг сайн бодож 25 хүртэлх хувиар нэмэгдүүлэх гэж оруулах . 20. Нийгмийн ажилтны нийтлэг баталгаа буюу 84-р зүйл дээр тухайн салбарын мэргэжилтэн үндсэн ажилтны цалингийн хэмжээнээс багагүй цалин хөлсөөр хангагдах тухай оруулах; 21. Хуулийн төслийн нэр томъёо хэсэгт нийгмийн ажилтан ба нийгмийн ажлын тухай оновчтой тодорхойлолт оруулах; 22. Олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагад ажилладаг нийгмийн ажилтны ажлын нөхцөлийн талаар тусгах; 23. Нийтлэг үндэслэл дээр жендерийн эрх тэгш байдлыг хангах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Ерөнхий боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийг оруулах; 24. Хуулийн төслийн 6 дугаар зарчим дээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг ялгарахгүй байх гэдгийг тусгах; 25. Улс үндэстний онцлог, соёлын ялгаатай байдал зэргийг зарчмуудад тусгах; 26. Нийгмийн ажилтныг мэргэжлийн мэргэшсэн нийгмийн ажилтан мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах тухай зохицуулалтыг хуульд тусгах; 27. Нийгмийн ажлын нэгдсэн зөвлөгөөн хийх гэдгийг оруулах;
	боловсруулсан бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Нийгмийн ажлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Ахмадын настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно. Хуулийн төслийн 2 дугаар зүйл. Нийгмийн ажлын хууль тогтоомж 2.1.Нийгмийн ажлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль

		28. Нийгмийн ажилтнуудыг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах заалтыг тусгах; 29. Нийгмийн ажилтнуудын хүүхэд хамгаалал болон үйлчилгээний зардлыг нийгмийн ажилтанд хэрхэн өгөх талаар зохицуулах заалт нэмэх, (нийгмийн ажил үйлчилгээ үзүүлэх багцалсан зардлаар хангах гээд оруулах) 30. Нийгмийн ажлын зарчим дээр нийгмийн хөгжил, хувь хүний хөгжил алийг нь дэмжихийг тодорхойлох 31. Нийгмийн ажилтны эрхийн тухай оруулах 32. Нийгмийн ажилтнууд орон нутагт үр дүнгийн урамшуулал авахгүй байгааг зохицуулах заалтыг оруулах;	тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. гэж тусгасан.
	2025 оны 01 сарын 27 ШУТИС- Төв номын сан 604 тоот ШУТИС-ийн Нийгмийн ажлын хөтөлбөрийн багт түшиглэн зохион байгуулагдсан “НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛУУД:	1. Үг, үсэг, найруулгын алдаа засах Жишээ нь: 4.1.1-д “үйлчлүүлэгчид” гэдгийн араас таслал тавих 4.1.5-д Эсхүл үү? Эсвэл үү? 5.1-д нийцсэн гэдэг үгний араас зай авах 5.1-д шийдэх аргаа гэдгийг шийдвэрлэх арга замаа” гэж солих 7.1-д Нийгмийн ажлын шууд ба шууд бус үйлчилгээ гээд 1 дүгээр эгнээнд нэг л оруулах. – 8.2-д :дүрэмдээ гэснийг дүрэмд гэж солих, 12.4-д үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдал буюу ; -г хасах 23.1-д ахлахын өмнө Нийгмийн ажилтан гэх юм уу нэг зэрэг ангилалтай байлгах 2. 5р Нийгмийн ажил энэ хэсгийг ;Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4-р зүйлд оруулах 7-р зүйл. Нийгмийн ажлын тогтолцоо ойлгомжгүй байна. Тогтолцоо нь оролцогч талуудыг хамруулах гэж байна уу? явагдах үйл ажиллагааны хүрээг илэрхийлэх гээд байна уу? 9-р зүйлд Нийгмийн ажлын шууд ба шууд бус үйлчилгээг тайлбарлан оруулан 3.Хүний хувийн мэдээллийг хамгаалах хуульд нийцэж байгаа эсэх 4. Нийгмийн ажилтны карьер хөгжил зураглалыг оруулах	Хуулийн төслийн найруулгыг ахин хийж үг үсгийн шинжтэй алдаа, даюхардал хийдлийг арилгаж ахин боловсруулсан. Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийн зорилго нь нийгмийн ажил, үйлчилгээний дэд бүтэц болох нийгмийн ажилтны мэргэжлийн хүрээ, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байгаа бөгөөд салбар дундын уялдаа холбоонд суурилсан нийгмийн ажлын үйлчилгээг тусгаж, боловсруулсан. Нийгмийн ажилтны мэргэжлийн хариуцлагын тогтолцоог бий болгоно. Нийгмийн ажилтан нь аль ч салбарт ажиллаж байгаагаас үл хамааран нэгдсэн арга зүй, нэг стандартаар хэрэгжүүлэх, тайлагнах, ёс зүй мэргэжлийн хариуцлагын тогтолцоотой болно. Ингэхийн тулд мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэж, түүнтэй холбоотой мэргэжлийн үргэлжилсэн сургалтын тогтолцоотой болгохоор тусгасан.
5.	2025 оны 06 сарын 26 Төрийн ордон дахь хэлэлцүүлэг	1. Эрүүл мэнд, гэмт хэргийн зардал буурна аа гэдгийг оруулах 2. нийгмийн ажилтны эрх ашгийг яаж хамгаалах талаар хаана орсон бэ 3. Эмзэг бүлэг гэдгийн зорилтот бүлэг гэх	НИЙГМИЙН ажилтны эрх ашгийг хамгаалахтай холбоотой мэргэжлийн холбооны эрх үүргийг тодорхой болгож хуулийн төслийн 37 дугаар зүйлийн

	4. шууд шууд бус үйлчилгээ гээд л байна микро мезо макро түвшинд ажиллана гээд байгааг орхигдуулсан 5. 4.1.2 бол яг энэ 3 тал үйлчилгээ мөн хэдий ч энэ хуулиар болбол үйлчилгээ хязгаарлах юм аа гэдэг нэг ийм жижигхэн заалт болбол аягүй том зөрчил авчирч магадгүй. 6. АНУ-ын лицензтэй нийгмийн ажлын мэргэжилтэн болчихсон одоо аа Канадад болохоор нийгмийн үйлчилгээний мэргэжилтэн болчихсон за Австралид болохоор олон нийтийн үйлчилгээний мэргэжилтэн болчихсон Солонгос нийгмийн халамжийн мэргэжилтэн нь нийгмийн хамгааллын мэргэжилтэн гээд 2 салаад ингээд үйлчилгээгээ үзүүлээд мэргэжлийн нэр томьёотой болоод явчихжээ. Бид олон улсын жишигт хүргэж өөрчлөх үү. 4 1.3 дээр санал гаргаж байна. 7. ШУТИС-н төгсөгч нар нийгмийн ажилтан гээд ажилд орохоор цалингийн шатлал хүртэл ажилтан гэдгээрээ доошоо ороод байна. 31.2 дээр ажилтан биш бүр ажилчид гээд л биччихсэн байна. Зарим газар иргэн хүн би нийгмийн ажилтан гээд хэлээд явж болох болсон харагдана. 8. 2 талт хэлэлцээр гэдэг зүйл бол хамгийн бас зөв зүйтэй санал байна. 9. Нөлөөллийн үйлчилгээ, Урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэдэг зүйлийг оруулах 10. 40.1 дээр 40.1.3 ч болгодог юм уу энэтэй холбоотой нийгмийн ажлын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага нь нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэдэг бүүр тусад нь заах хэрэгтэй. 11. Эрсдэлтэй хүнтэй нийгмийн ажилтан хүн одоо ажиллахад бэлэн болчихлоо гээд сэтгэл зүйг нь ур чадварыг нь хэдий хугацаанд дадлагажуулж сургаад үйлчлүүлэгчтэй ажиллах юм бэ гэдэг хэсгийг бас энэ юун дээр хуулийн хэсэг дээр бас оруулж өгвөл зүгээр юм болов уу 12. Нийгмийн ажилтан хүн мэргэжлийн үйлчилгээгээ мэргэжлийн түвшинд үзүүлчихлээ гэдгийг нь хэн хянаж хяналт оруулах юм. Өөрөө мэргэжлийн түвшинд байлаа гэдгийг хэн үнэлж дүгнэх юм. Нийгмийн ажилтны эрх ашгийг хэн, хэрхэн хамгаалах вэ 13. Үйлчлүүлэгчийн хэрэгцээ гэдэг үг аягүй их орсон байна. Тэгэхээр үйлчлүүлэгчийн хэрэгцээ хүний хэрэгцээ бол хязгааргүй. Тэгэхээр бид нар үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн	37.2.10-т “хуульд заасан тохиолдолд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах,” зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн төслийн ТАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН АЖИЛТНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, БАТАЛГАА гэж шинээр тусгаж. 36 дугаар зүйл. Нийгмийн ажилтан 37 дугаар зүйл. Нийгмийн ажилтны нийтлэг эрх, үүрэг гэж дэлгэрэнгүй тусгаж, тухайн ажил мэргэжлийн онцлогийг тусгасан. Хуулийн төсөлд 23 дугаар зүйл. Нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд гэж тусгайлан зааж, мөн зүйлийн 23.1-т “Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхээр дүрэмдээ заасан мэргэшсэн хуулийн этгээд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлнэ.” гэж заан зарим шаардлагыг нэмж тусгасан. Тухайлбал төслийн : 23.2.1.хоёроос доошгүй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтантай байх; 23.2.2.нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх; 23.2.3.үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх; 23.2.4.хүсэлт гаргагч хуулийн этгээд нь дотоод журамдаа нийгмийн ажлын үйлчилгээний үндэсний стандартад нийцсэн аргачлалыг тусгасан байх; 23.2.5.хүсэлт гаргагч хуулийн этгээд нь өөрийн дотоод журамдаа санхүүгийн
--	--	---

	үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангасан үйлчилгээг үзүүлнэ гэдэг үгүүд их байна. Тэгэхээр тэр хүний хэрэгцээ хязгааргүй нийгмийн ажилтан хүн үзүүлнэ гэдэг бас хэцүү. Тэгэхээр тэр хэрэгцээ гэдэг үгийг одоо өөр мэргэжлийн хэллэгээр оруулах 14. нийгмийн халамжийн тухай хууль дээр магадлан итгэмжлэл гэдэг зүйл чинь одоо нөгөө шинэ хуулиараа байхгүй болчихсон байгаа. Тэгэхлээр энийг бас дахиад эргэж хармаар юм уу дахиад өөр тусдаа магадлан итгэмжлэл яриад байна уу? 15. Цагдаа, шүүх, батлан хамгаалах салбарын нийгмийн ажилтан сэтгэл зүйн хувьд маш хүнд нөхцөлд ажилладаг. Эдгээр байгууллагуудын нийгмийн ажилтнуудын ажлын дараах аюулгүй байдал тэдгээрийг даван туулах чадварын асуудал энэ хуульд багтсан байгаа юу гэж асуумаар байна? 16. Нийгмийн ажил гэж юу вэ гэдгийг тодорхойлолтыг л эргэж харах, мэргэжилтэн гэж хэн юм бэ, Ирээдүйд бол тэртээ тэргүй энэ салбар руу хувийн хэвшил орж ирнэ. Тэгэхээр алсыг харсан байдлаар томъёолоод өгөх	төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах; Дээрхи шаардлагыг үндэслэн “23.5.Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанаас энэ хуулийн 24.5-д заасан саналыг үндэслэн Мэргэжлийн хороо нийгмийн ажлын үйлчилгээ явуулах хуулийн этгээдийг 3 жилийн хугацаагаар магадлан итгэмжилнэ. 23.6.Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар 15 хоногийн дотор Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанд мэдэгдэж бүртгүүлнэ.” гэж тусгасан.
2025 оны 07 сарын 04 Нийгмийн ажлын хуулийн төсөлд хүргүүлэх санал 6. НА-ын чиглэлээр доктор хамгаалж буй Г.Золжаргалан багшийн санал. (мэйлээр ирүүлсэн)	1. Хуулийн 7-р зүйлд: 7.1. Хувь хүн, гэр бүлд үзүүлэх шууд тусламж үйлчилгээ: 1. Хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ 2. Амьдралын хүнд нөхцөлөөс гарахад чиглэсэн дэмжлэг, тусалцаа 3. Эрсдэлт бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ 4. Нийгэм - сэтгэл зүй, эрүүл мэндийн дадал зуршлын зөвлөгөө 5. Нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх 6. Төлөөлөл хэрэгжүүлэх 7. Тусламж үйлчилгээний зохицуулалт 7.2. Байгууллага, олон нийтэд үзүүлэх шууд тусламж үйлчилгээ: 1. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2. Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж буй байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг судалгаа, нотолгоонд тулгуурлан боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх;	Хуулийн төсөлд 7 дугаар зүйл. Нийгмийн ажлын шууд үйлчилгээний төрөл 7.1.Нийгмийн ажлын шууд үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд: 7.1.1.хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ; 7.1.2.амьдралын хүнд нөхцөлөөс гарахад чиглэсэн дэмжлэг, тусалцаа; 7.1.3.эрсдэлт бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ; 7.1.4.олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа; 7.1.5.нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн дадал, зуршлын зөвлөгөө;

	18-р зүйл: Шууд бус тусламж үйлчилгээ: 1. нийгмийн ажлын судалгаа; 2. нийгмийн бодлогын нөлөөлөл; 3. олон улсын нийгмийн ажил;	7.1.6.нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх; 7.1.7.төлөөлөл хэрэгжүүлэх; 7.1.8.тусламж үйлчилгээний зохицуулалт.
Сургуулийн Нийгмийн ажилтын нийгэмлэгээс ирүүлсэн санал 2025 оны 09 дүгээр 11-ний өдөр №25 албан бичгээр	1.Хуулийн төслийн 2.1 заалт дээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Олон Улсын Нийгмийн Ажилтнуудын Холбоо гэж оруулах 2. 4.1.3 заалт иргэн гэдгийг хасах 3. 7.1 Нийгмийн ажлын шууд үйлчилгээний үндэс нь урьдчилан сэргийлэх үйлчилгээ байдаг учраас 7.1.1 Урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэж эхлэх - 16.2 найруулга, нэр томьёог зөв бичих, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих 4. 16.3 Олон улсын байгууллага- Олон Улсын Нийгмийн Ажилтнуудын Холбоо болон нийгмийн ажлын мэргэжил өндөр хөгжсөн орны нийтээр хүлээн 5. Мэргэжлийн холбооны бүтцийг хуулийн төсөлд тусгах, олон жил тууштай ажилласан салбарын мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран гүйцэтгэх гэж, мэргэшлийн зэрэг гэдэг нийгмийн ажилтан ажиллуулж байгаа яамны шийдэх асуудал, гэхдээ хуулинд нийгмийн ажилтан мэргэшлийн зэрэгтэй байна гээд оруулах 6. 30.9.5.өөрийн эрх хэмжээний хүрээ гэж юуг хэлж байна вэ, нэгэнт батлаад гаргасан салбарын хууль, дүрэм журмыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлэх ажлыг мөрдүүлэх 7. 37-р зүйл нийгмийн ажилтны эрх 37.1.1 нэмэх - Нийгмийн ажилтан хүний эрхийг хамгаалагч, иймээс Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хуультай нийцүүлэх - Хүний болон хүүхдийн эрхийн зөрчил болон холбогдох асуудлаар ямар ч албан тушаалтанд гомдол, санал, нэхэмжлэл гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй гэж нэмэх Салбарын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан төрийн үйлчилгээний албан тушаалтанд хамаарах эрхийг эдлэх (орон сууц, эрүүл мэнд, халамж г.м) - Хүний эрхийн болон хуухдийн эрхийн асуудлаар эрсдэлт нөхцөлд ажиллахад цагдаагийн байгууллагын дэмжлэг туслалцаа авах эрхтэй - 37.2 нийгмийн ажилтны үүрэгт хамтын хариуцлага хүлээнэ гэж оруулах	1.Монгол Улсын Үндсэн хуульд олон улсын гэрээний талаар заасан тул тодорхой нэг баримт бичиг буюу Хүний эрхийн түгээмэл тунхаглал гэдгийг нэмээгүй. 2.Төслийн 4.1.3-т заасан “Иргэн” гэдгийг “мэргэжилтэн” болгож өөрчилсөн. 3.Хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан зарим үйлчилгээ нь урьдчилан сэргийлэх чиг үүрэгт хамаарч байгаа ба тусгайлан дээрхи төрлийн үйлчилгээг нэмэх шаардлагагүй гэж үзсэн. 4.Олон Улсын байгууллага, холбоо гэдгийг тухайн хуулийн төсөлд тусгайлан заах шаардлагагүй гэж үзсэн. 5.Хуулийн төслийн 40 дүгээр зүйл. Мэргэжлийн удирдлага, үргэлжилсэн сургалт, 41 дүгээр зүйл. Мэргэшсэн нийгмийн ажилтан. гэж тусгасан. Тус хуульд нийгмийн ажилтныг Хүний эрхийг хамгаалагчийн хуульд заасны дагуу хамгаалах, тухайн хуулийн үйлчлэлд оруулах боломжгүй, хуулийн зорилт нь өөр тул тусгаагүй болно. Хуулийн төслийн 37 дугаар зүйлийн 37.2.10-т “хуульд заасан тохиолдолд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах;” зохицуулалтыг тусгасан тул хамтын хариуцлагатхй холбоотой саналыг тусгаагүй.

7.

		9. 39-р зүйл хориглох Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хуулийг хараарай 10.44-р зүйл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай холбох мэдээллийн сан хамгийн чухал, мэдээллийг архивын материал болгон хадгалах гэдэгт анхаарч оруулах	
	https://d.parliament.mn 60-аас доошгүй хоног хуулийн төслийг байршуулж ирүүлсэн саналууд	Сүнжидмаа: Санал1: 2.3. Монгол Улсын хууль тогтоомжид нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны талаар тусгайлан заасан бол нийгмийн ажлын хууль тогтоомжид хамаарна. - энэ хэсгийг илүү өргөн утгаар ойлгогдохоор оруулах нь зөв. Ж.нь:нийгмийн ажлын хууль тогтоомжид хамаарна..... гэдгийг дэлгэрүүлэх. МУ-ын хуулиа дагах юм уу үгүй юу гэдэг нь тодорхой ойлгогдохгүй байна. 3.2. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын иргэнд энэ хуульд заасан нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлнэ.нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ... гэж оруулбал ойлгомжтой байхаар байна 3.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа харьяалалгүй энэ хуульд заасан нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үзүүлж болно. гэснийгхарьяалалгүй иргэнд энэ хуульд заасан..... гэж оруулбал ойлгогдохоор байна 4.1.1. "Нийгмийн ажил" гэж нийгмийн хөгжил, өөрчлөлт, нийгмийн эв нэгдлийг дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг хангах, тэднийг чадавхжуулахад чиглэсэн мэргэжлийн арга зүй бүхий цогц үйл явцыг;нийгмийн эв нэгдэл..... гэдэг хэсгийг олон нийт ойлгогдохоор оруулах 4.1.3. "Нийгмийн ажилтан" гэж Нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх шинжлэх ухааны мэдлэг, ур чадвар, хандлагатай, дээд боловсрол эзэмшсэн эсхүл түүнтэй дүйцэхүйц цогц чадамжтай ажилтан, албан хаагч, иргэнийг; албан хаагч, иргэн гэдэг үгийг хасаадажилтан эсвэл мэргэжилтэнг... гэж оруулах	Санал 1: Иргэн Сүнжидмаагаас ирүүлсэн саналыг хуулийн төсөлд тусгаж 2 дугаар зүйлийн 2.3, 3 дугаар зүйлийн 3.2, 3.3, 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3-ийг тус өөрчлөв. Үүнтэй холбоотойгоор Намуун, Мөнгөнтуяа нарын нийгмийн ажилтны талаархи тодорхойлолтод өгсөн саналыг мөн хүлээн авч хуулийн төсөлд тусгав. Санал 2: Тухайн хуулийн төслийн 8 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн холбогдох хэсэгт дурдсан саналуудыг хуулийн төсөлд тусгасан. Санал 3: Хуулийн төсөлд магадлан итгэмжлэлийг түтгэлзүүлэхтэй холбоотой заалтыг хасч магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаа нь сайн дурын үйл явц байхаар тусгасан. Мөн мэдээллийн сантай холбоотой зохицуулалтыг эргэн харьж улсын төсвөөс эхний удаа санхүүжүүлж цаашд мэргэжлийн холбоо өөрө өхөгжүүлж авч явах байдлаар тусөлд тусгав.
8.			

МӨНГӨНТУЯА: Дээд боловсрол эзэмшсэн эсхүл түүнтэй дүйцэхүйц цогц чадамжтай ажилтан, албан хаагч иргэнийг гэдгийг хасах

Санал 3: 8.1. Хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэхэд дэмжих, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хамаарна...гэснийг..... Хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ гэдэг нь хүний мэдлэг, ур чадвар, хандлага, нийгмийн харилцаа болон сэтгэл зүйн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны цогц юм.

СҮНЖИДМАА

14.1. Хүн өөрийн эрүүл мэнд, сэтгэл зүй, нас, хөгжлийн бэрхшээл, орон зай болон цаг хугацааны нөхцөл байдлын улмаас өөрийн эрх, ашиг сонирхолыг илэрхийлж, нийгмийн ажлын үйлчилгээг авах боломжгүй эсхүл хязгаарлагдсан тохиолдолд нийгмийн ажилтан нь тухайн хүний өмнөөс төлөөлөл хэрэгжүүлнэ. гэснийгтүүнийг төлөөлөх ойр дотны хүн байхгүй бол нийгмийн ажилтан нь төлөөлөл хэрэгжүүлж болно.....гэж оруулсан нь дээр байх. НА хүн маш олон ажил давхцдаг тул 1 хүний асуудал дээр төлөөлөл хэрэгжүүлээд яваад байх боломж бололцоо хир байгааг судлах хэрэгтэй. Ялангуяа боловсролын НА-ны хувьд их том асуудал

14.2. Нийгмийн ажилтан нь хууль тогтоомжид заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлэхдээ үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлж оролцоно.

.....төлөөлөл хэрэгжүүлэхээр оролцвол..... гэж оруулж өгөх

15.2. Тусламж үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ кейс менежмент, эмнэлэгээс гаргах төлөвлөлтийг хийнэ.эмнэлэгээс гаргах төлөвлөлтгэдгийг хасах

СҮНЖИДМАА

	22.1. Нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг тухайн салбарын хуулиар эрх олгосон төрийн байгууллага, түүний ажилтан нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ. Гэснийгнийгмийн ажлын чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн мэргэжлийн нийгмийн ажилтан нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлнэ.... гэж тодорхой оруулах. Учир нь энэ ажлыг мэргэжлийн хүн мэргэжлийн түвшинд хийх ёстой 22.5. Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага нь үзүүлж буй нийгмийн ажлын шууд үйлчилгээнийхээ талаар бүртгэл хийж, энэ хуульд заасан мэдээллийн санд бүртгүүлнэ. гэснийг бүртгэлийн мэдээлэл нь салбар бүрт тохирсон мэдээллийг агуулсан байх нь чухал. Ж нь: Сургуулийн нийгмийн ажилтны бүртгэл мэдээлэлд анги удирдсан багш, ангийн хамт олон, найз нөхдийн хүрээний асуудал их хамаардаг учраас энд салбар салбараар нь маш сайн тодорхой болгож байж мэдээлэл үнэн зөв бүртгэгдэх сайн талтай. НАМУУН: Жишээ нь хорооны халамжийн мэргэжилтэнд өөрсдийн хувийн програмаас иргэдийн мэдээлэл үндсэн оршин суугаа хаягийг харах боломжтой байдаг бол Хорооны хөгжлийн нийгмийн ажилтан маш олон судалгаа гаргадаг ч ямар ч програм мэдээллийн систем байдаггүй хэсгийн ахлагч нараасаа тодотгон гаргадаг. Энэ нь судалгаа бодитой үнэн зөв гарахад хүндрэлтэй байдаг. Салбар бүрийн нийгмийн ажилтнууд өөрийн ажлын хүрээнд мэдээллийн систем, програмтай байх СҮНЖИДМАА: 23.2.1. хоёроос доошгүй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтантай ..Нийгмийн ажилтны тоог зааж байгаа бол Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хоёроос доошгүй нийгмийн ажилтантай гэж оруулах 23.3. Нийгмийн ажил үйлчилгээг бие даан эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 24.2-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл дараах баримт бичгийг бүрдүүлэн Нийгмийн ажилтны холбооны Ажлын албанд хүргүүлнэ: гэснийг Нийгмийн ажилтны холбоо нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага байж	
--	--	--

чадах уу? гэдэг дээр маш сайн анхаарах хэрэгтэй. Төрийн байгууллагаас давуу эрхтэй байж болох эсэх нь эргэлзээтэй байна.

24.1. Энэ хуульд заасан нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын шууд үйлчилгээг Нийгмийн ажилтны холбооны нэгдсэн бүртгэлд бүртгүүлсний үндсэн үзүүлэх ба нийгмийн ажлын мэргэжлийн дүрмийг баримтлан ажиллана.

СҮНЖИДМАА: Салбар бүрт ялгаатай байх болов уу. Боловсролын салбарын НА-ууд гэхэд БШУЯ-түүний харьяа байгууллага, төсвийн шууд захирагчаасаа ажлын байр нь, үзүүлж байгаа үйлчилгээ, үйл ажиллагаа нь шууд хамаардаг учраас эргэн харах шаардлагатай.

25.2. Энэ хуульд заасан нийгмийн ажлын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийгмийн ажилтан нь нийгмийн ажилтны холбооны гишүүнчлэлтэй байх бөгөөд нийгмийн ажилтан мэргэжилтэй этгээд нь гишүүн байж болно.

СҮНЖИДМАА

Ерөнхийлөгч нь мэргэшсэн нийгмийн ажилтан тэр дундаа салбарын онцлогт тохируулан тэргүүлэхээс дээш мэргэжлийн зэрэгтэй нийгмийн ажилтан байна гэж зааж өгөх, **ЭРДЭНЭЦЭЦЭГ** Ерөнхийлөгч нь нийгмийн ажилтан байна.

СҮНЖИДМАА

Удирдлагын байгууллага гэдэг дээр анхаарах. Удирдах зөвлөл биш байгууллага мэтээр ойлгогдож байна.

СҮНЖИДМАА

31.1. Нийгмийн ажилтаны мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Нийгмийн ажилтаны мэргэжлийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх болон нийгмийн ажилтаны ёс зүйн сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох, нийгмийн ажилтаны ёс зүйн асуудлаар судалгаа хийх зэрэг ажлыг нийгмийн холбооны нийгмийн ажилтаны мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороо /цаашид "Ёс зүйн хороо" гэх/ зохион байгуулна.

	СҮНЖИДМАА Ёс зүйн хороо ба Мэргэжлийн хариуцлагын хороо гэсэн 2 ийн аль нэг нэршлийг нь л хэрэглэх СҮНЖИДМАА нийгмийн ажилтны мэргэжлийн холбоо..... 31.2. Ёс зүйн хороонд нийгмийн ажилтаны ёс зүйн асуудлаар судалгаа хийдэг, нийгмийн ажилтны мэргэжлийн сургуульд тухайн чиглэлээр хичээл заадаг професор болон нийгмийн ажилтаны ёс зүйн боловсролыг дээшлүүлэх, ёс зүйн хувьд нийгмийн ажилтаныг манлайлах эрмэлзлэлтэй нийгмийн ажилчид сайн дураар нэгдэн ажиллана. ТӨГӨЛДӨР 39.1.1. улс төрийн үйл ажиллагаа явуулах, улс төрийн намын гишүүнчлэлтэй байх; Улс төрийн намын гишүүнчлэлгүй байх шаардлага нь иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж буй. Улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй байх нь улс төрөөс ангид байхыг илэрхийлж болох ч гишүүнчлэлтэй байх эсэх нь хүний эрхийн асуудал болох тул хасах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд заавал хариу өгөхийг хүсье. СҮНЖИДМАА 42.1. Нийгмийн ажлын үйлчилгээний мэдээлэл гэж дор дурдсан агуулга бүхий бичгэн, дуу авиа, дүрс бичлэг, цахим болон бусад хэлбэрийн өгөгдлийг хэлнэ.....салбар нийгмийн ажлын үйлчилгээний онцлогт тохируулан ялгаатай байлгах 43.9. Мэдээллийн сан нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ашиглаж болно. хувь хүний нууцыг хамгаалах асуудлыг маш сайн анхаарч шийдэхгүй бол олон үйл ажиллагаа нэгдэх, олон хүн оролцох тусам хувь хүний нууц алдагдах эрсдэл өндөр болно.	
--	---	--

	45.3.4. Хэрэглэгчийг мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах; 47.2. Мэдээллийн сангийн мэдээлэл нь төлбөртэй болон төлбөргүй байна. Төлбөргүй болон нийтэд зориулсан мэдээллийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Нийгмийн ажилтны мэргэжлийн холбоо эсвэл салбар хариуцсан төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална гэж оруулах 47.3. Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийн тухай мета мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй.....энэ заалтыг хасах ямар ч ач холбогдолгүй	
НИЙГМИЙН АЖЛЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН САНАЛ ДҮГНЭЛТ		
Д/д	Санал, дүгнэлт	
1.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 15-д “хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал: нийгмийн халамжийн бодлого: хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт” нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар хуульчилсан. Дээрх асуудлын хүрээнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, тогтолцоог Нийгмийн халамжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт тодорхойлохдоо “нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхлэнэ” гэж, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ” гэж тус тус заасан. Иймд хуулийн төсөлд тусгасан нийгмийн ажил, үйлчилгээ, нийгмийн ажилтны эрх зүйн байдал, удирдлага, зохион байгуулалтын талаарх зарим зохицуулалт нь дээрх хууль тогтоомжид заасан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын эрхлэх	Тус хуулийн төслөөр нийгмийн халамжийн нийгмийн ажилтны эрх зүйн байдал түүнтэй холбоотой харилцааг зохицуулахгүй бөгөөд харин нийгмийн ажлын үндсэн төрөл, хэлбэр, Нийгмийн ажил мэргэжлийн онцлог, нийтлэг тавигдах шаардлагыг тусгаж байгаа болно. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан засгийн газрын болон яамны, агентлагийн чиг үүрэгтэй давхардуулахгүйгээр тус хуулийн төслөөр нийгмийн ажлын үндсэн төрөл, хэлбэрийг тогтоохоор зохицуулсан. Түүнчлэн Мэргэжлийн нэгдсэн холбооны хууль нь ерөнхий зохицуулалттай бөгөөд тухайн холбооны удирдлага, хороодын нарийвчлан зааж, түүнийг хэрхэн

	асуудал, бүрэн эрх, чиг үүрэгтэй давхцаж, хуулийн давхардал, хийдэл, зөрчил үүсэж болзошгүй байна;	байгуулахыг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулах шаардлагатай байсан тул Нийгмийн ажилтны мэргэжлийн холбооны талаар нарийвчилсан зохицуулалтыг болон завсрын хугацааны зохицуулалтыг хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан.
2.	Хуулийн төсөлд төрийн бус байгууллагын буюу Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг зохицуулахаар тусгажээ. Мэргэжлийн холбооны үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар тус тус зохицуулдаг бөгөөд Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлж болохоор заасан тул хуулийн төсөлд тусгасан мэргэжлийн холбооны үйл ажиллагааг дээрх хуулийн хүрээнд зохицуулах боломжтой. Түүнчлэн, хуулийн төслийн гол зохицуулалт болох Нийгмийн ажилтны мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулах, холбооны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, мөн нийгмийн ажилтнуудыг холбооны гишүүнчлэлтэй болгох, гишүүнчлэлийн хураамж төлөх зэрэг асуудлын талаар хуулийн төслийн тандан судалгаанд тусгаагүй, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн дунд хуулийн төслийг хэлэлцүүлж, санал авсан эсэх нь тодорхойгүй байна. Иймд хуулийн төсөл, үзэл баримтлал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан хуулийн төслийн үзэл баримтлалыг судалгаа хийсний үндсэн дээр боловсруулах, хуулийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулах гэсэн хуулийн шаардлагад нийцэхгүй байна;	Мэргэжлийн холбооны хуулиар хуулийн төсөлд тусгасан холбоог байгуулах, үйл ажиллагааг зохицуулахад хэт ерөнхий байдлаар зохицуулсан байсан тул холбооны тухай тусгайлсан бүлэг оруулж, үйл ажиллагаа, чиг үүргийг тусгасан. Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийг үзэл баримтлал, Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батласан аргачлалын дагуу боловсруулсан. Тус хуулийн төсөлд олон нийтээс тус хуулийн төсөлд draftment сайтад ирүүлсэн 32 санал, 2024 оны 11 сараас 2025 оны 9 сарын 18-ны өдрийг хүртэл хугацаанд 11 удаагийн, давхардсан тоогоор 820 гаруй нийгмийн ажилтныг хамруулсан хэлэлцүүлгээс гарсан 250 орчим санал, Засгийн газрын санал, дүгнэлтийг тусган нийт 7 бүлэг 49 зүйлтэйгээр боловсруулсан. Уг хуулийн төсөлд заасан нийгмийн ажилтны мэргэжлийн холбоо баайгуулах, хөгжүүлэхийг бүгд дэмжсэн.
3.	Хуулийн төслийн зардлын тооцоололд хуулийн төсөлтэй холбоотой анхын хөрөнгө оруулалт 0.8 тэрбум төгрөг, цаашид жил бүр 96.5-160.0 тэрбум төгрөг шаардагдах бөгөөд ажилтны тоог харгалзан төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 2025 оны түвшинд хадгалах, Улсын Их Хурлын 2025 оны төлөвлөгөө"-д төсвийн урсгал зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасантай тус тус нийцэхгүй байна;	Зардлын тооцоололд хуулийн төсөлтэй холбоотой анхын хөрөнгө оруулалт 0.8 тэрбум төгрөг байхаар заасан ба цаашид тус зардлыг холбоо харуусахаар өөрчилсөн. Тухайлбал, төслийн 47 дугаар зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт гэсэн зүйлд 47.1.Мэдээллийн санг бүрдүүлэхэд улсын төсвөөс нэг удаа санхүүжүүлэх бөгөөд

	цаашид Нийгмийн ажилтны холбоо хариуцна. гэж өөрчилсөн.	
4.	Хуулийн төсөл Нийгмийн ажилтны мэргэжлийн холбоог нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх, түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох чиг үүрэгтэй байхаар тусгаж, хуулийг төслийг дагалдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нийгмийн ажлын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг Нийгмийн ажилтны мэргэжлийн холбоо олгох заалтыг нэмэх тухай хуулийн төсөл боловсруулжээ. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу зөвшөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл нь мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзах бөгөөд мөн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 болон 5 дахь хэсэгт заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ерөнхий сайдын дэргэдэх орон тооны бус зөвлөлийн санал, дүгнэлт гаргуулах шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй;	Зөвшөөрлийн тухай хуулийн төслөөр зохицуулах шаардлагагүй гэж үзсэн ба хуулийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг итгэмжлэх үйл ажиллагаа сайн дурын шинжтэй байхаар төсөлд өөрчлөлт оруулсан. Тухайлбал боловсорлын багц хуульд заасан магадлан итгэмжлэл, Хүүхэд хамгаалын тухай хуульд заасан магадлан итгэмжлэл нь зөвшөөрлийн шинжийг агуулдаггүй ба тухайн үйлчилгээнд итгэж болно гэдгийг баталж буй баталгаажуулалт хэмээн үздэг.
5.	Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй бологох үндсэн чиглэлд Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, өргөн мэдүүлэхээр заасан. Нийгмийн ажил, үйлчилгээг сайжруулах, салбар дундын уялдааг хангах, хүн амын тодорхой бүлэгт нийгмийн ажил, үйлчилгээг хүргэх, суурь хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн ажлын тогтолцоог сайжруулах зорилгоор анхдагч хуулийн төсөл боловсруулахаас илүүтэйгээр хуулийн төсөлд туссан зарим зохицуулалтыг Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд болон салбарын бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хууль тогтоомжийн уялдааг хангах, зохицуулалтыг сайжруулах байдлаар шийдвэрлэх боломжтой;	Анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулах нь зүйтэй хэмээн хэлэлцүүлэгт оролцогчид, хууль санаачлагч үзсэн.
6.	Хуулийн төсөл, дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл нь "Аргачлал батлах тухай" Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-д заасан анхдагч хуулийн төсөл эх бичвэрийг боловсруулахад тавих шаардлага болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй, үг, үсэг утга найруулгын илэрхий алдаатай байгааг дурдах нь зүйтэй байна." гэжээ.	хуулийн төслийн эх бичвэрт тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй, үг, үсэг утга найруулгын илэрхий алдааг засварлав.

№	Өргөн барих хуулийн төслийн бүрдүүлбэр	Хуудас
1	Үзэл баримтлал (Эх хувиараа)	7
2	Дэлгэрэнгүй болон товч танилцуулга	10
3	Хуулийн төсөл	20
4	Дагах хуулийн төсөл	7
5	Дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл	2
6	Хэрэгцээ шаардлагын тандан судалгаа	15
7	Үр нөлөөний үнэлгээ	9
8	Зардлын тооцоолол	9
9	Засгийн газрын санал дүгнэлт	4
10	ТББ, ИНБ-уудаас албан бичгээр ирүүлсэн саналууд	33
11	Саналын товъёг	17
	Нийт хуудасны тоо	133